

Улс төр

төсөл

Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль “хөг”-өө алдав уу

Хуулийг батлах гэсээр байтал гадаадын хөрөнгө оруулагч банкуудын идэвх суларчээ

П.Батбөх
ЗГМ

УИХ-ын гишүүн Б.Жавхлан, Б.Батзориг, Б.Ундармаа нарын 18 гишүүн Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төслийг 2016 онд өргөн барьсан ч парламентаар хэлэлцэлгүй өдийг хүрлээ. Уг нь тус хуулийн төслийг 2016 онд УИХ-аас тэргүүн ээлжинд батлах шаардлагатай хууль, шийдвэр, тогтоолын төслийн жагсаалтад багтаасан юм. Тухайлбал, жагсаалтын 1.3.5-д “Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн орчныг сайжруулах”, 1.3.7-д “Банк, санхүүгийн системийн ил тод байдлыг хангаж, гадаадын банкны салбар нэгж нээн ажиллуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох” гэж заасан байв. Гэвч таван чуулган дамнуулан хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулсан ч хойшлуулсаар буй. Ирэх хаврын чуулганы жагсаалтад ч эл хуулийн төслийг тусгаад байна.

Тус хуулийг санаачлагч УИХ-ын гишүүн Б.Жавхлан хуулийн төслийг олон чуулган дамжуулан хойшлуулсанд сэтгэл дундуур байна. Тэрбээр “Энэ хуулийг батлах гэсээр байтал гадаадын хөрөнгө оруулагч банкуудын идэвх суларлаа. Эдийн засгийн ийм нөхцөлд хөрөнгө оруулалт хийх банк олдох болов уу гэж санаа зовж байна. Уг нь хуулийн төсөл өргөн барьж байх үед гадаадын банкууд манай эдийн засагт хөрөнгө оруулалт хийх сонирхол их байсан. Гэвч одоо нөхцөл байдал өөр болсон учир хуулийн ач холбогдол хэр үр өгөөжтэй байхыг мэдэхгүй юм” хэмээсэн юм. Мөн тэрбээр Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн “эгшиглэх” цаг өнгөрч, “хөг”-өө алдсанд харамсаж буйгаа нуусангүй. Гэхдээ хуулийн төслийг яаралтай баталж, эрх зүйн орчныг бүрдүүлэх нь цаашид санхүүгийн

зах зээлд том дэвшил болно гэсэн бодолтой хэвээр байгаа юм.

Монгол Улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагад элсэхдээ санхүүгийн зах зээлийг нээлттэй болгох үүрэг хүлээсэн. Түүний үрээр манай улсад 2008 оноос хойш олон улсын санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг, нэр хүнд бүхий гадаадын банкууд төлөөлөгчийн газраа нээн ажиллуулж байна. Мөн өнөөдөр дотоодын банкны салбарт үйл ажиллагаа явуулж буй 14 банкаас найм нь гадаадын хөрөнгө оруулалттай, гурав нь гадаад хувьцаа эзэмшигчтэй болсон. Харин гадаадын банкууд хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчин бүрдээгүйгээс бие даан үйл ажиллагаа явуулах боломжгүй байгаа юм. Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль батлагдсанаар манай улсын эдийн засагт хувь нэмэр оруулах олон гарц бий болно.

Гадаадын хөрөнгө оруулалттай банк манай улсад орж ирснээр санхүүгийн системийн өрсөлдөөн нэмэгдэхийн зэрэгцээ бүтээмж өсөж, зээлийн хүү буурах, шинэ технологи, сайн туршлага, ноу

хау нэвтрэх, чанаргүй зээлийн хэмжээ буурч, хүртээмж нэмэгдэх зэрэг олон эерэг үзүүлэлт гарна гэж Хуулийн төсөл санаачлагчид тооцсон.

● **Дотоодын банкны салбарт үйл ажиллагаа явуулж буй 14 банкнаас найм нь гадаадын хөрөнгө оруулалттай, гурав нь гадаад хувьцаа эзэмшигчтэй болсон.**

● **Гадаадын банк зөвхөн томоохон төсөл хөтөлбөрүүд санхүүжүүлэхэд шаардлагатай зээлийг хуулийн этгээдэд олгох бөгөөд иргэдээс хадгаламж авах, тэдэнд зээл өгөхийг хориглоно.**

● **Дотоодын санхүүгийн зах зээлд өрсөлдөөн нэмэх нэгэн хуулийн төсөл “эгшиглэх хөг” нь өнгөрсөн ч банкны салбарт хөгжлийн эрч нэмэхээр “дуншсан” хэвээр.**

Харин хуулийн төслөөр Монголбанк гадаадын банкинд хөрөнгө оруулалтын чиглэлээр дотоодын зах зээлд нэвтрэх зөвшөөрөл олгоно. Ингэхдээ зөвхөн томоохон төсөл хөтөлбөрүүд санхүүжүүлэхэд шаардлагатай зээлийг гагцхүү хуулийн этгээдэд олгох болон гадаад, дотоодын төлбөр тооцоо гүйцэтгэх, зээлийн баталгаа, батлан даалт жаргах, үнэт цаас худалдах, худалдан авахыг зөвшөөрч, бусад үйл ажиллагааг хориглохоор тусгасан. Өөрөөр хэлбэл, иргэдээс хадгаламж авах, тэдэнд зээл олгохыг хориглох юм. Мөн гадаадын банкинд дээрх эрхийг олгохдоо Монголд нэг жилээс доошгүй хугацаагаар төлөөлөгчийн газраа ажиллуулсан байх шаардлагыг тавьж байгаа. Түүнчлэн хөрөнгө оруулалтын банкны дүрмийн сан 500 тэрбум төгрөг байхыг шаардана. Гэхдээ хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад үүнийг өсгөх нь тодорхой. Учир нь манай дундаж банкуудын актив 800 тэрбумаас 1.5 их наяд төгрөг байгаа юм.

Монголд үйл ажиллагаа явуулах гадаадын банкнийг хянах процесс Банкны тухай хууль

болон энэ хуульд заасан зарим зүйл заалтаар хязгаарлагдана. Үүнээс анхаарал татсан нэг заалт бий. Тэр нь “ТУЗ-ийн хараат бус гишүүний бүрэлдэхүүнд нэгээс доошгүй Монгол Улсын иргэн орсон байх” гэсэн заалт юм. Тухайн иргэн нь УАБЗ-өөс томилогддог байх таамаглал ч бий. Шалтгаан нь хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүд төсөлд нэмэлтээр УАБЗ-өөс давхар хяналт тавих заалт оруулахаар ярилцаж байгаа юм. Тухайлбал, гадаадын төрийн өмчийн оролцоотой банк орж ирэх тохиолдолд УАБЗ-ийн шийдвэрийг харгалзан үздэг байх саналыг гишүүд гаргасан аж. Мөн хяналтын зохицуулалтыг стратегийн ач холбогдол бүхий салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах хууль, журамд нарийвчлан тусгах юм.

Дотоодын санхүүгийн зах зээлд өрсөлдөөн нэмэх нэгэн хуулийн төсөл “эгшиглэх хөг” нь өнгөрсөн ч банкны салбарт хөгжлийн эрч нэмэхээр “дуншсан” хэвээр. Санхүүжилт дутагдаж буй том төсөл хөтөлбөрүүд ч хэрэгжих цагаа хүлээж, тоосонд дарагдсаар байна. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» **ПАРЛАМЕНТ**
АН-ынхан парламент дахь бүлгээ татан буулгаж зөвлөлийн статустай ажиллахаар болжээ. УИХ-ын Хаврын чуулганы эхэнд тус намынхан Л.Болд гишүүнийг АН-ын бүлгээс гарсныг УИХ-ын даргад албан ёсоор уламжилснаар бүлэг тарсанд тооцох юм.

» **ЗАСГИЙН ГАЗАР**
ЗГХЭГ, Халх голын байлдааны ялалтын 80 жилийн ойг тэмдэглэх ажлын хэсгээс Дорнод аймгийн Халх гол сумыг жишиг сум болгохоор ажилдаа оржээ. Тус ойн хүрээнд Оросын армийн нисэх хүчний үзүүлэх тоглолтыг тус суманд зохион байгуулахаар төлөвлөж байна.

» **ЯАМ**
БСШУСЯ-наас гадаадад суралцуулах сонгон шалгаруулалтыг зарлажээ. Өнөө жил Польш, Украин, Вьетнам, Болгар, Лаос, Куба, Беларусь, Казахстан улсад 86 оюутан суралцуулах бөгөөд ирүүлсэн бичиг баримтад нь үнэлэлт, дүгнэлт өгөх хэлбэрээр суралцах иргэдийг тодруулах аж.

» **НИЙСЛЭЛ**
Нийслэлийн Засаг даргын А/76 захирамжаар ирэх сарын 1 хүртэлх хугацаанд нийслэлийн ЕБС, цэцэрлэгээс бусад сургалтын үйл ажиллагаа, олон нийтийн арга хэмжээ, кинотеатр, үзвэр үйлчилгээ болон ресторан, нийтийн хоолны газарт 0-10 насны хүүхдэд үйлчлэхгүй байхыг холбогдох газруудад үүрэгджээ. Захирамж зөрчсөн иргэнийг 100 мянга, ААН-ийг нэг сая төгрөгөөр торгох юм.

» **ТОМИЛГОО**
УИХ-аас томилогдсон Төрийн албаны зөвлөлийн шинэ гишүүд хуралдаж даргаа сонгов. Бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдсан тэд анхны хурлаараа гишүүдийн олонхын санал авсан Б.Баатарзоригийг Төрийн албаны зөвлөлийн даргаар томилжээ.

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

Д.Лүндээжанцан: Ээлжит бус чуулганыг ирэх сарын дундуур зарлахаар тогтсон

Хаврын чуулган Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд анхаарлаа хандуулна

Г.Билгүүн
ЗГМ

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Д.Лүндээжанцан ирэх хаврын чуулган болон ээлжит бус чуулганы бэлтгэл ажил хийгээд Үндсэн хуулийн өөрчлөлтийн талаар хэвлэлийнхэнд мэдээлэл өглөө.

-УИХ-ын дарга Г.Занданшатар намрын чуулганы төгсгөлд ээлжит бус чуулган зарлахаа мэдэгдсэн. Та энэ талаар ямар мэдээлэлтэй байгаа вэ?

-Даргын зөвлөлийн хурлаар ээлжит бус чуулган хийнэ гэж тохирсон. Ирэх сарын 10-ны үеэр зарлана. Ээлжит бус чуулган



зарлах шаардлага бий. Хаврын чуулганаар хэлэлцэх асуудлууд шахуу байгаа. Зөвхөн манай байнгын хороотой холбоотой хуулиуд гэхэд л Сонгуулийн гурван хууль, Улс төрийн намын тухай хууль, түүний санхүүжилттэй холбоотой хууль, Засаг захиргаа, түүний удирдлагын тухай хууль гээд олон хууль бий. Тийм учраас ажлын хэсэг байгуулах хэлэлцүүлэг хийх гээд ажил бий. Үүн дээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэнэ. Үндсэн хуулийн өөрчлөлтийг ярихын

өмнө Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг хөндөх тухай ярьж байна. Эдгээртэй холбоотой бэлтгэл ажлыг хангана. Харин ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудал нь тодорхой, гаргах шийдвэр нь бэлэн болсон асуудлуудыг хэлэлцдэг дэгтэй. Тийм учраас хийхийн тулд л ээлжит бус чуулган зарлачихдаггүй юм.

-Ээлжит бус чуулган хэд хоногийн хугацаатай хуралдах вэ?

-Гуравдугаар сарын 15 хавьд зарлаад 14 хоног хуралдах байх.

-Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд эхлээд өөрчлөлт оруулна гэхээр Үндсэн хуулийн дархлаа сулрах юм биш үү?

-Энэ хуулийг бид ягштал дагаж мөрдөн ажиллах ёстой. Би энэ хуульд аль болох халдахгүй, хөндөхгүй гэсэн байр суурьтай байгаа.

-Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудал олон парламент дамжлаа. Энэ удаагийн парламент өөрчлөлт хийж чадах болов уу?

-Энэ парламентаар өөрчлөх нийгмийн захиалга бий. Шинэ

Үндсэн хууль хэрэгжээд 28 жил боллоо. Нийгэм нь урагшлаад явчихсан учраас Үндсэн хуульдаа зарим тодотгол, нэмэлт өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага үүсжээ гэдгийг ард түмэн ойлгож байгаа. Парламент зарим эрхээсээ татгалзаад, Засгийн газарт олгоё гэж байгаа.

-Зарим хүмүүс Ерөнхийлөгчийн эрх мэдлийг нэмэх нь гээд, нөгөө хэсэг нь Ерөнхий сайдад илүү эрх мэдэл олгоно гэж талцаж байна?

-1992 онд Үндсэн хуулийг батлахдаа Ерөнхийлөгчийн эрх мэдлийг тодорхой заагаад өгчихсөн. Энэ удаад бид тэр эрхэд нь халдахгүй гэж төлөвлөж байгаа. Харин Засгийн газрын зарим эрх нэмэгдэх юм. Парламент нь төрийн эрх барих дээд байгууллагын хувьд, төлөөллийн байгууллагын хувьд гол амин чухал асуудлуудаа шийддэг, Засгийн газар нь эрх мэдэлтэйгээр хуулийг хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгох өөрчлөлтийг хийнэ. Парламент нь хуулиа тогтоож Засгийн газартаа хариуцлага тооцож чаддаг тогтолцоог жинхэнэ утгаар нь бий болгоё л гэж зорьж байгаа. [ЗГМ]

АЙЛЧЛАЛ

Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн зөвлөхөөр Энэтхэгийн компани ажиллана

УУХҮ-ийн сайд Д.Сумъяа-базар энэ өдрүүдэд Бүгд Найрамдах Энэтхэг улсын Дели хотноо зохион байгуулагдаж буй “Петротек” газрын тос, байгалийн хийн олон улсын чуулга уулзалтад оролцож боловсруулах үйлдвэр барьж байгуулахаар шийдвэрлэснийг уламжилж төслийн хэрэгжилт, ойрын хугацаанд хийж гүйцэтгэхээр төлөвлөж буй ажлаа танилцуулжээ.

Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн менежментийн зөвлөхийг сонгох тендерийг хоёр улсын хооронд байгуулсан зээлийн ерөнхий хэлэлцээрийн дагуу БНЭУ-ын “Эксим” банкаас урьдчилсан сонгон шалгаруулалт зохион байгуулж, “Инженерс Индиа Лимитэд” компани шалгарсан бөгөөд тус компани манай улсад төлөөлөгчийн газраа нээн

ажиллуулахаар болжээ.

Түүнчлэн “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК болон БНЭУ-ын “Инженерс Индиа Лимитэд” компанийн хооронд хамтран ажиллах тухай Санамж бичгийг үзэглэлээ.

“Петротек 2019” олон улсын хуралд газрын тос, байгалийн хийн хайгуул, олборлолт, боловсруулалт, борлуулалтын сүлжээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын 6000 гаруй аж ахуйн нэгж, байгууллага өөрсдийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулжээ. Мөн чуулганы хүрээнд дэлхийн 27 улсын Засгийн газрын гишүүн, сайд нар оролцсон 20 орчим салбар хуралдааныг хийсэн байна.

Айлчлалын үеэр УУХҮ-ийн сайд Д.Сумъяабазар Энэтхэгийн газрын тосны компаниуд болон Технологийн Их Сургуулийн Уул уурхайн сургуулийн удирдлагатай уулзан, монгол оюутан, суралцагчдыг тус улсад газрын тосны гүн боловсруулалтын чиглэлээр сургаж, бэлтгэхэд хамтарч ажиллахаар санал солилцжээ. [ЗГМ]

Нийтлэлчийн булан

2016.02.21	2016.02.28	2017.03.25	2017.03.13	2017.03.12	2017.03.12	2017.03.12
						
Жавхлант шарга хурдан морины уралдаан	Төвийн бүсийн хаврын хурдан морины уралдаан	Дүнжингарав-2017	Засагт ханы хурд-2017	Дээлтэй цэнхрийн хурд-2017	Хутагтын хурд-2017	Ховдын Дөргөнд болсон хурдан морины уралдаан
Мориноос унасан 14	Мориноос унасан 16 Зүүн хөлний шилбэ хугарсан 2	Мориноос унасан 31 Гарын шуу хугарсан 1 Хөлийн шилбэ хугарсан 1	Мориноос унасан 3	Мориноос унасан 13 Толгойдоо бэртэл авсан 5 Хацрын яс цуурсан 1	Мориноос унасан 2	Нас барсан 1

ХЭҮК©

Хүүхдийн амины үнэтэй зэрлэг цэнгэлийг зогсоох аргагүй гэж үү!

Б.Энхжаргал
@enkhjrglZGM

Сар шинийн өмнө Сүхбаатар аймгийн Халзан сумын нутагт болсон хурдан морины үсэргээний үеэр арван настай хүүхэд мориноос унаж амь насаа алдсаныг холбогдох нөхөд “Морины ажил хийж яваад унасан” гэсэн ойлгомжгүй, утгагүй тайлбараар аргалаад өнгөрөх гэж оролдлоо.

Гэтэл энэ хэрэг явдлын шил дараад өнгөрсөн сарын сүүлийн долоо хоногийн амралтын өдөр Говьсүмбэр аймагт дахиад л гурван насны морьд уралдуулсан явдал болжээ. Мөн сар шинийн өдрүүдэд Хэнтийн Биндэрт болсон дааганы албан бус гэх уралдаанд оролцоод хоёр гараа хөлдөөсөн гэх зургаан настай хүүгийн боолттой гарны зураг олон нийтийн сүлжээгээр нэг цацгудлаа.

Хачирхалтай нь, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас энэхүү мэдээллийг няцааж, “Гар чийдэн бариад саахалтын айл руугаа явах замдаа тэр хүүгийн гар хайрагдсан төдий байна” гэх мэдээллийг өглөө. Харин уг мэдээллийг анх олон нийтийн сүлжээгээр дамжуулж нийгэмд хүргэсэн эзэн, хүүхдийн “Өнөр бүл” төвийн дэд захирал асан С.Амгалан “Хүүхдээс өөрөөс нь асуухад морь унаж байгаад ийм болсон” гэж хэлснийг нь онцлов. Хүүхдийн төлөө гэсэн авадил үүрэг зорилготой хоёр байгууллагын хэн нь худал ярьсныг мэдэхгүй ч, өвөл, хаврын хахир цагаар дур мэдэн зохион байгуулдаг хурдан морины уралдаанууддаа хэн, хэрхэн хариуцлага хүлээж, цаашид яаж хяналт тавих юм вэ? Байсхийгээд л хориглолоо хэмээн гаргадаг тогтоол, шийдвэрийг чинь дагаж мөрдөх баталгаа байна уу? гэдэг асуудал ямагт хариулт нэхсэн хэвээрээ үлддэг. Ер нь алив наадам, уралдаан тэмцээн сайхан ч, хүүхдийн амь насыг эрсдүүлэн байж ийнхүү зугаацан цэнгэх явдал дэндүү харгис биш гэж үү!

Бид ийм зүйлийг эцэслэн шийдэж чадахгүй бол цаашид хүүхдийн төлөө гэж худал ярих шаардлага огт алга. Монголын морин спорт, уяачдын холбооны



www.mn-nhrc.org©

шинэ тэргүүн Ц.Батсайхан хаврын уралдааныг зохион байгуулахгүй бол уяачид мал маллах сонир-холгүй болж, хот хүрээ орох хандлагатай болсон талаар ярьсан байх юм. Дэндүү утгагүй, шал тэнэг сонсогдож байгаа биз.

Тэрбээр сар шинийн баярын өмнөхөн өдөр тутмын хэвлэлд өгсөн ярилцлагадаа “...Сая болсон уяачдын VII их хурал дээр орон нутгийн төлөөлөгчид хаврын морин уралдааныг зохион байгуулахгүй бол хөдөө орон нутгийн залуу уяачдын идэвх буурч, малаа өсгөх эрмэлзэлгүй болж, хот хүрээ орох хандлагатай болж байгаа талаар санал хэлж байсан. Хаврын уралдаан зохион байгуулах талаар уяачдаас санал хураахад 100 хувийн дэмжлэг авсан. Уяачид битүүнд бөх барилддаг шиг сар шинээр морь уралдуулах санал ирсэн. Үүнийг бид дээш уламжлах үүрэгтэй” гэсэн байх юм. Уяачдын хүсэл сонирхлыг ихээр дээдэлж байгаа холбооны дарга харин унаач хүүхдүүдийн эрхийн талаар бүтэн нүүр ярилцлагадаа нэг ч дурдаагүй байна билээ. Тэр эрхэмд уяачдын хүсэл зориг хүүхдийн амь наснаас даанч агуу зүйл гэнэ дээ. Өөрөө морь уралдуулах асар дур сонирхолтой байж болох ч ийм хэрцгий хандаж болохгүй. Монгол Улсын Засгийн газар ч зугаацаж

ханадаггүй уяачдаасаа ялгарах юм алга.

Өвөл хаврын морин уралдааныг зохион байгуулахыг хориглох талаар тогтоолын төслийг Шадар сайд Ө.Энхтүвшин ноднин санаачлаад, бараагүй. Засгийн газрын хэд хэдэн хуралдааны хэлэлцэх асуудлын дараалалд оруулдаг ч, яг хэлэлцэх болохоор хойшлуулчихдаг. Сүүлдээ санаачлагч Ө.Энхтүвшин өөрөө ч бууж өгөөд, энэ талаар хэвлэлд ярихаас бөргөх болсон юмдаг. Ойрын эх сурвалж нь “За ёстой барахгүй юм билээ. Хааны уурга нь урт, хуйв нь уужим гэдэг үг чинь одоо уяачдынх болсон байна” хэмээн толгой сэгсэрч байв.

Хүүхдийн амь эрсдэж байхад үл тоодог атлаа уяачид гэх эрхмүүд хүлэг морь нь бахардаж үхэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр бараг эмгэнэл зарлах шахдаг болсон. Ийм болохоор тэдэнд Засгийн газраас гаргаж буй тогтоол, шийдвэр бол ёстой нохой хуцсан дайны биш. Цаашдаа ч өвөл, хаврын уралдаан ил далдаар зохион байгуулж, хийж л таарна гэж бичигч би итгэлтэй хэлж чадна.

Хүүхдийн эрхийг зөрчигчдөл тооцох хариуцлага нь инээдтэй гэмээр дэндүү бага байгаатай л энэ бүхэн холбоотой. Өөрөөр хэлбэл их, бага ямар ч хэмжээний уралдаан, үсэргээн, сунгаа зохион

байгуулагчдыг ердөө л 100 мянган төгрөгөөр торгодог гээд бод доо. Олом чангалж чадахгүй атлаа олон арван сая төгрөгөөр хурдан морь худалдаж авсан шинэ цагийн

баячуудад 100 мянган төгрөгийн торгууль гэдэг дэндүү инээдтэй. Ийм хөгийн зохицуулалттай учраас уяачид 100 мянган төгрөгөө бариад, “Бид торгуулиа төлөөд уралдаанаа зохион байгуулъя” гэж Засаг даргынхаа гэрийг гороолсон явдал гарч байхав. Тодруулж хэлбэл, Увс аймагт. Хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжлийн төлөө газрын хуульчийн хэлснээр 2018 онд хууль бусаар хурдан морины уралдаан зохион байгуулж, хүүхэд бэртэж, гэмтсэн, амь насаа алдсанаас болж зохион байгуулагч 12 уяачийг тус бүр 100 мянган төгрөгөөр л торгосон байна. (Зарим тохиолдлыг инфографикаар үзүүлэв)

Тэгвэл энэ хавар хэдэн уяач 100 “цаас” албаныхны өөдөөс шидчихээд, хэдэн хүүхдийн амь нас, эрүүл мэндээр цэнгэх бол? Үүнд л чанга хяналт, хатуу хариуцлага хэрэгтэй байна. Тэгээд ч уяачдыг дийлээгүй Засгийн газар өвөл, хаврын цагт морин уралдааныг зохион байгуулахыг хориглож чадаагүй тул аргаа барахдаа “өвлийн тэргүүн сараас тавдугаар

сарын 1 хүртэл 12 хүртэлх насны хүүхдийг морины уралдаанд оруулахыг хориглов” гэсэн арчаагүй шийдвэр гаргачихаад байгаа.

Аргаа барахдаа Хүний эрхийн үндэсний комиссоос хүйтний улирал буюу өвөл хаврын цагт хурдан морины уралдаан зохион байгуулахгүй, хүүхдээр хурдан морь унуулахгүй байх талаар Монгол Улсын Засгийн газарт болон Аймгийн Засаг дарга нарт удаа дараа зөвлөмж хүргүүлэхээс өөрийг хийж чадахгүй сууна.

Одооноос эхлээд Засгийн газар 12 настай хүүхэд морь унаж уралдахыг зөвшөөрсөн гээд болсон болоогүй баахан уралдаан, үсэргээн хийгээд унах вий. Тэгээд ч 12 той хүүхэд гэдэг биеэ даах нас биш. Мөнгөнд улайран бооцоо тавьсан өнөө цагийн баячуудын зэрлэг зугаа цэнгэлээс Монголын балчир үрс, охид, хөвгүүдийн амь нас үрэгддэг явдлыг эцэслэн цэглэх аргагүй юм гэж үү! Арай ч дээ! [ЗГМ]



УЛААНБААТАР ХОТЫН БАНК



20 жил
Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих банк



Улаанбаатар Хотын Банк 20 жилийн ойдоо зориулж үндэсний брэндийг хөгжүүлж буй бизнес эрхлэгч та бүхэнд дараах зээлийг санал болгож байна.

1. ҮНДЭСНИЙ БРЭНДИЙГ ДЭМЖИХ ЗЭЭЛ

Зээлийн хугацаа	12 сар
Зээлийн хэмжээ	50,000,000 төгрөг хүртэл
Зээлийн хүү	13 хувь
Ашиглагдаагүй үлдэгдлийн хүү / сарын/	0.2 хувь /Зээлийн шугам/
Барьцаа хөрөнгө	Үл хөдлөх хөрөнгө, Баряаны тэмдэг, Гэрээгээр баталгаажсан авлага
Өргөдлийн хураамж	10,000 төгрөг

* Зээлийн бодит өртөг /сараар/: 1.17%

2. ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ЗЭЭЛ

Зээлийн хугацаа	36 сар
Үндсэн зээлээс чөлөөлөх хугацаа	12 сар
Зээлийн хэмжээ	50,000,000 төгрөг хүртэл
Зээлийн хүү	18 хувь
Хөнгөлөлттэй хүү*	15.6 хувь

* Монгол улсын үндэсний хэв маяг, өв соёлыг хадгалсан бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэх гэж байгаа тохиолдолд хөнгөлөлттэй хүүгээр олгох

Барьцаа хөрөнгө	Үл хөдлөх хөрөнгө
Өргөдлийн хураамж	10,000 төгрөг

* Зээлийн бодит өртөг /сараар/: 1.53%

Эрт дээр үеэс уламжлагдан ирсэн үндэсний өв соёлын бүтээлүүдээ дэлхийн зах зээлд таниулахад Улаанбаатар Хотын Банкны “Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих” энэхүү зээл танд түлхэц болох бизээ.

info@ubcbank.mn

1800 1800

www.facebook.com/ubcbank

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр: “Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн нутаг дэвсгэрт баригдах 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт урьж байна.

Хийгдэх ажлын мэдээлэл:

Тус барилга нь төмөр бетон каркас, блокон дүүргэлттэй 2 давхар, нийт 1220 м2 талбайтай

Тендер захиалагч: “ЭКО АЛТАН ЗААМАР” ХХК

Бүрдүүлэх материал:

- Ажил эрхлэх Тусгай зөвшөөрөл болон гэрчилгээ
- Танилцуулга, бүтээлийн тайлан
- Багийн бүрэлдэхүүн
- Ажил гүйцэтгэх төлөвлөгөө, график
- Угсралтын ажлын үнийн санал албан бичгээр
- Ажлын төсөв

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн байгууллага дээрх материалуудыг төслийн нэр дээр хаяглан дугтуйнд хийж битүүмжлэн 2019 оны 02-р сарын 20-ний 17.00 цагаас өмнө доорхи хаягаар ирүүлнэ үү! Сонирхсон этгээд дэлгэрэнгүй мэдээллийг дараах дугаарын утсаар холбогдож лавлана уу. 99019163, 88969819

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Бүгд Найрамдах Болгар улсын Элчин сайдын яамны байр



Нэг улс НҮБ-ын татварын 22 хувиас дээш хувиар төлөхгүй байх, хамгийн ядуу гишүүн улс гэхэд ногдуулах татвар нь 0.001 хувиас буухгүй байх ёстой.



НҮБ-ын нийт төсвийн 0.005 хувийг Монгол Улс төлдөг

Олхонуд Баярхүү
профессор

Манай улс НҮБ-ын татварт хэчнээн төгрөг төлдөг бол? Жирийн монгол хүний санаанд энэ тухай сэтгэх цаг зав гарахгүй л дээ. Албатай ч биш. Гэхдээ улсын нууц шахуу авч үздэг учраас тэр тоог нууцалдаг. Доллараар төлж таарна. Хэрвэ ил зарлаад, жил бүр мэдээлдэг болгочихвол нэг бодлын амар. Гэхдээ одоо цаг нь биш. Монголын гурван хүн тутмын нэг

[ЗГМ СОНИН]

"Засгийн газрын мэдээ" сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
Эдитор З.Цэлмэг
Утас: 99901526

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайвны өргөн чөлөө,
"Блю Скай тауэр" 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР

zgmn.mn
ubinfo.mn

Дугаарын удирдагч
Г.Баярсайхан

8658000629112

001077

НҮБ-ын төсөв бүрдүүлэлтэд Азийн орнуудын оруулдаг хувь хэмжээ

Филиппин •
0.1%

ТАЙЛАНД •
0.2%

МАЛАЙЗ •
0.3%

СИНГАПУР •
0.4%

ИНДОНЕЗ •
0.5%

ЭНЭТХЭГ •
0.7%

НИЙТ 2017

► \$5.6 ТЭРБУМ

япон
9.6%

БНСУ
2.0%

АВСТРАЛИ
2.3%

БНХАУ
7.9%

Азийн бусад орнууд

ПАКИСТАН	0.093%
ВЬЕТНАМ	0.058%
ШРИ-ЛАНК	0.031%
БРУНЕЙ	0.029%
МЬЯНМАР	0.010%
БАНГЛАДЕШ	0.010%
НЕПАЛ	0.006%
МОНГОЛ	0.005%
КАМБОЖ	0.004%
ЛАОС	0.003%
БУТАН	0.001%

ANN/DataLEADSUnited Nations©

нь байнга шахуу ядуу зүдүү явдаг, аж төрөх гэж үхэлтэй нүүр тулж байгаа тул “НҮБ-д ямар их мөнгө өгдөг юм”, “ямар ашиг байна”, “яах гэж төлдөг юм”, “ядуурлыг бууруулахад НҮБ юугаар тусалсан юм” гэж ирээд л туйлшрахад манайхан яг эхэхэстэй байгаа.

Надад болон миний амьдралд ямар ашигтай юм гэх шалгуур тавьдагийг нь буруутгах гэсэнгүй. Гэхдээ санааг нь амруулах ганцхан баримт дурдсу. Гишүүн орнуудын татвараас бүрддэг НҮБ-ын нийт төсвийн 0.005 хувийг Монгол Улс төлдөг юм. Үгчилбэл ТЭГ МЯНГАНЫ ТАВАН ХУВЬ. Ойролцоогоор жилдээ 124 мянган ам.доллар.

НҮБ-ын төсөв гэж ингэхэд юу юм бэ? Энэ нь тус байгууллагын байнгын төсөв, энхийг сахиулах ажиллагааны төсөв, олон улсын эрүүгийн шүүхэд зориулах үлдэгдэл төсөв гэж гурван янз буй. НҮБ-ын дүрмийн дагуу Ерөнхий Ассамблей төсөв хэлэлцэж батална. НҮБ-ын гишүүн орнуудад ногдох татварын хувь хэмжээг Ерөнхий Ассамблей гурван жилээр (жил бүр төд гэхчлэн) тогтоож өгнө. Захиргааны ба төсвийн асуудал эрхлэх зөвлөлдөх хороо гэж 18 гишүүнээс бүрдэх мэргэжилтний ажлын хэсгээс төсвийн төслийн анхны хувилбар бэлтгэгдэж, тэр нь Ерөнхий Ассамблейн 5 дугаар хороогоор хэлэлцэгдэнэ. Тус хороонд гишүүн бүх улс харьяалагдана. Энэ тухай un.org/ru/ga/fifth сайтаас тодруулж болно.

НҮБ-ын төсвийг хоёр жилийн хугацаагаар баталдаг. Нэг санхүүгийн жил нь нэгдүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31 хүртэл үргэлжилнэ. 2018-2019 оны төсвийг 5.397 тэрбум ам.доллараар баталсан ба одоо хэрэгжиж байна.

Юунд зарцуулах нь ойлгомжтой. Нью-Йорк дахь НҮБ-ын нарийн бичгийн дарга нарын газар, Женев, Вена, Найроби дахь салбар оффисуудын хөтөлбөрийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Мөн НҮБ-ын бүс нутгийн эдийн засгийн комиссууд, бусад болон тусгай улс төрийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ.

Санхүүжилтийн цаана гишүүн орнуудаас татварт хандивлах мөнгөн дүн их чухал. Хэн их мөнгө төлнө, тэр хэрээр НҮБ-д илүү эрх дарх эдэлнэ гэсэн бичигдээгүй дүрэм үйлчилнэ. Гишүүн орнуудын төлбөрийн чадвар, түүнийг тооцоолох шалгуур нь сүүлийн жилүүдийн макро эдийн засгийн үзүүлэлт, үндэсний нийт орлого, үндэсний валютынх нь ханшийн савлагаа, хүн ам тутамд ногдох орлогын хэмжээ гэхчлэн олон хүчин зүйлээр тооцоолж байж татварын хувь хэмжээ тодордог. Нэг улс НҮБ-ын татварын 22 хувиас дээш хувиар төлөхгүй байх, хамгийн ядуу гишүүн улс байлаа гэхэд нэгдүгээр жилдээ 2018 оны татвар төлж байсан тохиолдол байдаг юм билээ.

2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганд оролцох хувь надад тохиож байв. Тэр үед 2016-2018 оны төсөв баталсныг би сайн санаж байна. Тэр хуваарилалт (хүснэгтээс харна уу) одоо ч мөрдөгдөж байгаа болов уу. Ямар ч гэсэн өндөр татвар төлөгч эхний 10 гишүүн улс дээр ийм хувь хэмжээ гарч байсан даа.

Энхийг сахиулах ажиллагааны төсвийг нэг жилээр баталж мөрдөнө. НҮБ-ын жил тутмын төсвөөсөө энэ төсвийг гаргах учраас санхүүгийн жил нь нэгдүгээр сарын 1-нээс дараа жилийн зургадугаар сарын 30-ны хооронд санхүүгийн жилээ тооцно. 2017-2018 оны нэг жилд 6.8 тэрбум ам.доллар

НҮБ-ЫН ТӨСВИЙГ ГОЛЛОН БҮРДҮҮЛЭГЧИД

№	ГИШҮҮН УЛС	ТАТВАРЫН ХУВЬ
1	АНУ	22%
2	Япон	9.68%
3	БНХАУ	7.921%
4	Герман	6.389%
5	Франц	4.859%
6	Их Британи	4.463%
7	Бразил	3.823%
8	Итали	3.748%
9	ОХУ	3.088% (одоо нэмэгдээд 3.9912 хувь болсон)
10	Канад	2.921%
Нийлбэр	НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүн улс	42.331% (Татварын бараг тал орчмыг нь)
Нийлбэр	Дээрх 10 гишүүн улс	68.892% (Гуравны хоёр хувь)

төсөвлөсөн. Герман энэ төсвийн 6.39 хувийг гаргаж, дэлхий дахинд энхийг сахиулахад мөнгөн хандив өргөсөн дөрөв дэх улс боллоо гэсэн мэдээ явж байв.

Одоо яг хаана төсөв зарцуулагдаж байна вэ. Жишээ татвал Сомалид материал-техникийн хангамжийн томхон бааз, Италийн Бриндизид үйлчилгээний глобал төв, Испанийн Валенсид холбоо нөөц төв, Угандын Энтебб дэх бүс нутгийн үйлчилгээний төв, бусад үйл ажиллагаа гэхчлэн 7.316 тэрбум ам.долларыг 2018 оны зургадугаар сарын 30 хүртэл зарцуулсан баримт буй. Энэ тухай un.org/peacekeeping; peacekeeping.un.org гэх сайтуудад бичээтэй байна. Мөн unmissions.org сайтаас мэдээлэл авч болно.

Уг төсөвт НҮБ-ын бүх гишүүн улс татвараа хандивлана. Татварын хувь хэмжээг тогтооно. Татвар төлөлөгчдийг гурван бүлэгт хуваана. Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд онцгой хариуцлага үүрдэг гэдгээрээ НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүд таван улсад ногдуулах татвар өндөр. Хоёр дахь бүлэг нь хөгжингүй орнуудаас бүрдэх ба НҮБ-ын

байнгын төсөвт төлдөг шигээ хэмжээний татварыг энхийг сахиулахад төлнө. Гурав дахь бүлэг орнуудад хөгжиж буй орнууд орох ба дотроо хэд хэдэн салбар бүлэгтэй. Хөгжлийн ялгаа зөрүү бий гэдгээрээ ангилагддаг. Гэхдээ НҮБ-ын байнгын төсөвт төлдгөөсөө багыг төлнө.

Хэн их мөнгө төлсөн нь илүү эрх эдэлнэ гэсэн бичигдээгүй дүрэм үйлчилдэг

Олон улсын эрүүгийн шүүхэд зориулах төсөв гэдэг нь хоёр жилийн хугацаагаар батлагдана. Жилийн эхний өдрөөс сүүлчийн өдөр хүртэл мөрдөнө. Өмнө нь Руандагийн талаар ажилласан олон улсын эрүүгийн шүүх, хуучин Югославын талаарх олон улсын шүүхийн зардалд төсөв нь үлэмж зарцуулагдаж байв. 2016-2017 онд 131.97 сая

ам.доллар төсөвлөсөн, 2018 онд зарцуулсан нь үлэмж хязгаарлаад 87.79 сая доллар байсан. Төсвийг бүрдүүлэхдээ арифметикийн дундаж хэмжээгээр улсуудад хуваарилан хувь тогтооно.

Ингэхэд татвараа цагт нь төлөөгүйн төлөө Ерөнхий Ассамблейн санал хураалтанд оролцох эрхээ хасуулж байсан тохиолдол бий болов уу? Энэ тухай НҮБ-ын дүрмийн 19 дүгээр заалт гэж бий. Өмнөх түүхэнд байсан уу гэвэл байсан юм билээ. 2018 оны есдүгээр сарын 25-ны байдлаар гурван улс татварын тооцоотой хэмээн санал хураалгах эрхээ хасуулж байжээ. Тэдгээр нь Коморын арлууд, Сан-Томе ба Принсипи, Сомали улс аж.

Манай улс арай ч ийм дээрээ тулахгүй нь тодорхой. Гэхдээ татвар төлөх нь гарцаагүй. Өртэй үлдэж болохгүй. Жилдээ ойролцоогоор 124 мянган ам.доллар төлж байгаа нь нэг хэсэгтээ үргэлжилнэ. Харин ШХАБ мэтийн бүс нутгийн олон улсын байгууллагад элсвэл төлөх татвар нь энэ дүнгээс даруй хоёр дахин, түүнээс ч илүү даваад явчих магадлалтай.

Ингэхэд НҮБ-ын татвар бүрдүүлэлт дээр БНХАУ идэвхийллээд байгаад анхаарал хандуулах хэрэгтэй. Дэлхий нийтээрээ л тэгж байна. Өөрсдийгөө хөгжиж байгаа орон гэж нэрлэх, тэгсэн хэрнээ аж үйлдвэржсэн хөгжингүй орнуудыг ардаа орхиод татвар төлөлтөөр манлайлаад эхэлсэн, гайхаш бараад ч байх шиг.

НҮБ-ын төсөв бүрдүүлэлт дээр Герман, Франц, Британийг алгасаад явчихсан, одоо гуравт бичигдэж байгаа нь тус улсын жин нөлөө, дуу хоолойг дэлхийн хамтын нийгэмлэгт нэмэгдүүлж байна, нэмэгдэх ч болно. Тун удахгүй НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, төрөлжсөн байгууллагуудын даргаар Хятадын дипломатч сонгогдоод гараад ирэхэд гайхах зүйлгүй болж байх шиг.

Хятадын ГХЯ-ны хэвлэлийн төлөөлөгч Хуа Чүнъян гэдэг нөхөр ингэж ярьсан байгаа юм. Юу гэвэл НҮБ-ын төсөв бүрдүүлэх гол зарчим бол гишүүн орнуудын төлбөрийн чадвараас шалтгаалдаг. Хятадын эдийн засгийн ерөнхий потенциал их боловч нэг хүн тутамд ногдох орлогын түвшин доогуур. Тэгэхээр хөгжиж буй орон хэвээрээ байна. Энэ бол Хятад хувьд төлбөр тооцоо хийх чадварын гол үндэс болно гэжээ.

Хятадын өөрийнх нь мэдээлж байгаагаар НҮБ-ын байнгын төсвийн хөрөнгө нийлүүлэгч хоёр дахь том гишүүн улс, мөн энхийг сахиулах төсвийг бүрдүүлэгч хоёр дахь том нь болсон гэжээ. Энэ тухай Хуа Чүнъян хэлэхдээ “НҮБ-ын саяхан баталсан шийдвэрээр ирэх гурван жилд Хятад нь НҮБ-ын байнгын төсөв, энхийг сахиулах төсвийн зардлыг бүрдүүлэх хэмжээгээ эрс нэмэгдүүлж, байнгын төсвийн 12 хувь, энхийг сахиулах төсвийн 15.2 хувийг тус тус бүрдүүлэх боллоо. Энэ бол Хятад нь дэлхийн хоёр дахь том эдийн засаг (эдийн засгийн цогц хэмээн өөрсдөө нэрлэдэг) болж, эдийн засгийн ерөнхий хэмжээ, нэг хүнд ногдох улсын эдийн засаг нэмэгдсэний үр дүн, мөн олон улс дахь Хятадын нэр нөлөө нэмэгдсэний илэрхийлэл мөн” гэжээ.

Нийгэм

ЗГМ ТОВЧХОН

» **ЭРҮҮЛ МЭНД**
Өчигдрийн байдлаар галзуу өвчний эрсдэлд өртсөн 29 тохиолдол бүртгэгджээ. Мал, амьтны дунд галзуугийн өвчлөл ихсэж буйтай холбогдуулан ЗӨСҮТ-өөс иргэдэд галзуу өвчний эрсдэлд өртөх аливаа эрсдэлээс сэргийлж, сонор сэрэмжтэй байхыг анхааруулж байна.

» **МӨНГӨН ДЭВСГЭРТ**
Сар шинийн өмнөхөн гүйлгээнд гарсан шинэчлэгдсэн 5000-ын дэвсгэртийг одоогоор орлогын АТМ-д хүлээж авахгүй байгаа аж. Тиймээс ХААН банкны бэлэн мөнгөний машинуудад шинэ дэвсгэртийг хүлээн авах хөгжүүлэлтийн ажил хийж байна.

» **ШАГНАЛ**
Олон улсын “Загасан нүд” кино фестивалийн шилдгүүдийг танилцууллаа. Энэ удаагийн наадамд манай улсын “Нүүдэлчдийн зурган өгүүлэмж” сангийн бүтээл “Бумбардай” кино хүүхэлдэйн киноны төрөлд шилдгээр шалгарч, гранпри шагнал хүртжээ.

» **ХУДАЛДАА**
Өнөөдрөөс “Хүчит шонхор” худалдааны төв ердийн цагийн хуваарийн дагуу ажиллана. Харин “Нарантуул” худалдааны төв маргаашнаас ажиллах юм.

» **ДУУДЛАГА**
Цагдаагийн байгууллага энэ сарын 4-11-ний өглөөний 08.00 цаг хүртэл өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллалаа. Энэ хугацаанд цагдаагийн байгууллагын 102 дугаарын угсанд 11,268 дуудлага, мэдээлэл ирсэн байна.

» **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**
"Монгол" телевизийн “Шарк танк” нэвтрүүлгээс Б.Индра гэх 10 настай охин шаркуудаас 25 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Тэрбээр “Бүжинд тохиолдсон хөгжилтэй явдлууд” бяцхан номоо гурван жилийн өмнөөс бичиж, ээжээрээ зураг зуруулан худалдаанд гаргажээ.

» **ХӨНГӨЛӨЛТ**
Татвар төлөгч, анх удаа амьдрах зориулалтаар орон сууц худалдаж авсан, барьсан иргэн хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт эдэлж, гурван сая хүртэлх төгрөгийн татварын хөнгөлөлт эдлэх боломжтой. Энэхүү хөнгөлөлтөд хамрагдах материалыг энэ сарын 15-ны өдөр хүртэл хүлээн авна.

Буриад руу нийлүүлсэн хиамнаас гахайн мялзангийн вирус илэрчээ



Монгол Улсад Африкийн гахайн мялзан өвчний халдварын тохиолдол 2019 оны нэгдүгээр сард бүртгэгдэж, одоог хүртэл халдвар авсан гахайнуудыг устгасаар байгаа. Тэгвэл манай улсаас уг өвчний вирус хил давсан талаар ОХУ-ын Регнум холбооны агентлаг, Буриадын Востоктелеинформ мэдээлжээ. Тодруулбал, энэ сарын 8-нд Өвөр Байгалийн Петровск-Забайкальскийн аймагт Африкийн гахайн мялзан илэрсэн

Цахилгаан менингит тархах аюул нүүрлэжээ



С.Батсайхан / ЗГМӨ

Менингококк гоц халдварын хоёр тохиолдол бүртгэгдлээ

«1
Өвчнийг тун түргэн хугацаанд зөв оношилж, эмчилснээр биений байдал нь сайжирсан хэмээн ЭМЯ мэдээлж буй ч нэг өвчтөний ард 30-40 хүн

халдвар тээдэг аж. Энэ өвчин өмнө нь манай улсад гарч байсан төдийгүй “цахилгаан менингит” нэрээр танил болсон. Уг нь манай хөрш хоёр улсад уг өвчин бүр сарын өмнө дэгдлээ хэмээн мэдээлж байсан төдийгүй ДЭМБ-аас ч анхааруулж байв. Гэтэл манай улсын эрүүл мэндийн байгууллагууд ямар ч арга хэмжээ авалгүй назгайрсаар байтал хэдийн ороод ирлээ.

Цахилгаан цахих мэт хурдан тархдаг энэ аюулт өвчин нь

арьсан дээр өвөрмөц, зөв биш хэлбэртэй, цусархаг тууралт гарах болон тархины зөөлөн бүрхүүл, тархины эдийн үрэвсэлээр илэрдэг амьсгалын замын цочмог халдварт өвчин юм. Тухайлбал, цоо эрүүл байсан хүүхэд гэнэт өндөр халуурч, 4-12 цаг, дунджаар 6-8 цагийн дотор биеэр нь тууралт өгөөд хамар, ходоод бөөр, өндгөвчнөөс цус алдалт, харвалт үүсдэг аюултай аж. Гэвч хүмүүс салхин цэцэгтэй

андуурах тохиолдол гардаг тул богино хугацаанд хүндэрч, амь нас эрсдэх аюултай энэ өвчний шинж тэмдэг илэрмэгц эмчид яаралтай хандахыг анхаарууллаа. Учир нь 2-4 дүгээр сард уг өвчний дэгдэлт эрс нэмэгддэг ба манай оронд найм, арав, 15 жилийн үечлэлтэй гардаг нь тогтоогджээ.

Цаашид энэ өвчний тохиолдол нэмэгдэх магадлалтай боллоо гэж ЭМЯ өчигдөр хэвлэлийхэнд мэдээлсэн юм. Угтаа өвчин

тархсан хойно нь мэдээлэх бус гарахаас нь өмнө сэрэмжлүүлж, арга хэмжээ авах үүрэгтэй бус уу. Жил бүр ямар халдварт өвчин хэдэн сард гардгийг мэддэг атлаа ЭМЯ болон НЭМГ-ын унхиагүй байдлаас болж иргэд вакцинд ч хамрагдах мэдээлэлгүй байсаар гарсан халдварт өвчин болгонд нэрвэгдэн, амь насаа алддагтай жил тутам эвлэрсээр байх уу. Тэр байтугай хатгаа, менингококк, улаан бурхан гэх мэт халдварт өвчнөөс сэргийлэх ганц арга нь вакцин хийлгэх гэдэг ч вакцинаа хангалттай нөөцлөх ч чадваргүй, ор дэр нэмж тавьснаа ажил хийсэн мэт пиардсаар байх уу.

Нэг өвчтөний ард 30-40 хүн халдвар тээдэг

Төсөвт мөнгө суугаагүйгээс вакцин авч чаддаггүй. Өвчин гарсан үед л хэдэн вакцин авдаг ч зорилтот бүлгийн хүмүүст арай гэж хүргэдэг хэмээн хэлээд сууж байх нь манай улсын эрүүл мэндийн бодлого болсон нь гутамшигтай. Ядаж нялхсаа вирус, нянгийн “хоол” болгочихгүй байх бодлогоор ажилладаг болмоор байна гэдэг хэдэн хатуу үгийг ЭМЯ болон НЭМГ руу илгээе. Түүгээр ч зогсохгүй ДЭМБ-аас удахгүй улаанбурхан өвчин дэлхий даяар тархахыг анхааруулсныг давхар дуулгая. Бодлого барьдаг, хэрэгжүүлдэг газрууд эртхэн хэрхэхээ шийдэх биз, цаг хугацаа бага үлдлээ. [ЗГМ]

мэдээ Хөвсгөл нуурын мөс цөмөрч, “Лексус-470” машин живжээ

Г.Санжааханд
ЗГМ

Энэ сарын 8-ны өдөр Хөвсгөл нуурын мөсөн дээгүүр зорчиж явсан “Лексус-470” загварын таван зорчигчтой суудлын автомашин мөсөнд цөмөрч усанд живжээ. Зорчигчид бүгд эсэн мэнд гарсан тухай дуудлага Онцгой байдлын байгууллагад бүртгэгджээ. Дуудлагын дагуу Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын 11 алба хаагч, хоёр автомашинтай нуурын усанд живсэн автомашиныг

татан гаргахаар 30 метрийн гүнд хоёр удаагийн шумбалт хийхэд автомашин дотор шороо хайрга их хэмжээгээр орсон байжээ. Түүнчлэн автомашин доторх эд зүйлсийг хайх боломжгүй учраас жолоочийн хүсэлтээр аврах ажиллагааг зогсоосон байна.

Энэ жил цаг агаар дулаан байсан болохоор мөсний даац хүн, мал, машин тэрэг явахад аюулгүй хэмжээнд хүрч бэх-жээгүй байгаа тул цаг хожих, зам товчлох зэргээр мөсөн дээгүүр явах, авто тээвэр хийхгүй бай-хыг анхаарууллаа. [ЗГМ]

“МИАТ” ТӨХК-Д 2019 ОНЫ ЗУНЫ НИСЛЭГИЙН ХУГАЦААНД ТҮР АЖИЛЛАХ АГААРЫН ХӨЛГИЙН ҮЙЛЧЛЭГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА



Тавигдах шаардлага:

- Англи хэлний мэдлэг: Англи хэлний ахисан-дунд (Upper-Intermediate)-аас дээш түвшний мэдлэгтэй байх. (TOEIC-ийн 500 эсхүл түүнтэй харгалзах IELTS, TOEFL, IBT-ийн оноотой байх)
- Хоёрдогч хэл: Орос, Герман, Хятад, Солонгос, Япон хэлний аль нэгийг эзэмшсэн бол давуу тал болно. (яриа болон бичгийн чадвартай)
- Нүдний хараа сайн байх
- Гадаад дүр төрх өв тэгш, эрүүл, гоо зүйд нийцсэн байх
- Ил харагдах шивээс, сорвигүй байх
- Ажлын ачаалал даах, харилцааны өндөр соёлтой, багаар ажиллах чадвартай, хариуцлагатай, нягт нямбай зан чанартай байх

Биеийн өндөр:

- Эр: 175-185 см
- Эм: 165-175 см

Нас:

- Эрэгтэй, эмэгтэй: 21-25 (Жич: Гадаад улсад агаарын хөлгийн үйлчлэгч бэлтгэх сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан 25-30 хүртэл насны эрэгтэй, эмэгтэй хүмүүс сонгон шалгаруулалтад оролцож болно.)

Бүрдүүлэх материал:

- Сонгон шалгаруулалтын анкетыг бүрэн бөглөсөн байх (www.miat.com хаягнаас татаж авах)
 - Бакалавр болон түүнээс дээш боловсролын гэрчилгээний хуулбар
 - Англи хэлний TOEIC /IELTS, TOEFL, IBT /-ийн шалгалтын онооны хуудас
 - Иргэний үнэмлэхний хуулбар
 - 3.5*4.5 хэмжээтэй цээж зураг 2 хувь
 - 9*12 хэмжээтэй бүтэн биеэр авхуулсан зураг 1 хувь, (Ажил хэрэгч хувцастай, засваргүй, сүүлийн 1 сарын дотор авхуулсан зураг)
- Материалыг “МИАТ” ТӨХК-ийн төв байрны 105 тоотод 2019 оны 02-р сарын 11-нээс 2019 оны 02-р сарын 18-ны өдрүүдийн /ажлын өдрүүдэд/ 09.00-16.00 цагийн хооронд хүлээн авна. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй хүмүүс дээрх материалыг гүйцэд бүрдүүлж, өөрийн биеэр дурьдсан хугацаанд авчирч өгнөүү. Материалыг хүлээн авах хаяг:

“МИАТ” ТӨХК-ИЙН ХАЯГ: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа-45, МИАТ компаний төв байр Холбоо барих утас: 7004-9958



Дэлхийн даяар финтек компаниуд бүтээлч устгалыг эрчимтэй өрнүүлж буй. Үүнээс үүдээд финтек болон санхүүгийн уламжлалт байгууллагууд өрсөлдөгч үү, аль эсвэл хамтрагч уу гэх асуулт зүй ёсоор тавигдаж эхэлсэн юм.

Ц.Оч
Forbes Mongolia

Бидний өдөр тутамд тулгардаг санхүүгийн үйлчилгээтэй холбогдох асуудлуудыг технологийн тусламжтайгаар шийдэж болно. Яг л ийм шалтгаанаар финтек хөгжиж эхэлсэн билээ. Финтек гэдэг нь санхүүгийн үйлчилгээ болон технологийн хөгжлийн нэгдэл юм. Товчхондоо, технологийн дэвшил, инновацын хялбар шийдлийг ашиглан санхүүгийн үйлчилгээг эцсийн хэрэглэгчид хялбар, хямд байдлаар хүргэж буйг финтек гэж ойлгож болно. Өдгөө хүмүүсийн амьдралд финтек эрчимтэй нэвтэрч эхлээд

старт-апууд томоохон хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаад эхэлжээ. Заримаас нь дурдвал, дэлхийн төлбөр тооцооны чиглэлийн аваргууд болох Stripe болон Visa компаниуд Нигерид гурван жилийн өмнө байгуулагдсан, төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг Paystack компанид хөрөнгө оруулаад буй. Тус компани Гана улс руу зах зээлээ тэлээд байгаа юм. Ер нь Африкийн старт-апуудын нэг онцлог нь тивийнхээ бусад улс руу зах зээлээ төвөггүй тэлэх боломжтойд оршдог аж. Монголд ч мөн финтек компаниуд бий болсон ба төлбөр тооцоо, зээлийн чиглэлээр түлхүү хөгжиж байна. Тэгэхээр манай улсад финтекийн өөр бусад чиглэлийг хөгжүүлэх орон зай хангалттай бий гэсэн үг. Банкн дээрний биеэр очиж дараалал хүлээх, бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх зэрэг бидэнд өдөр тутам тохиолддог санхүүгийн хэрэгцээг хялбар, хямд, хурдан шийдэж чадаж буй нь финтекийн давуу тал. Монголбанкнаас хийсэн

компани огт өөр байр суурьтай байгаа юм. Үнэхээр ч хөгжлийн явцдаа финтекүүд банк, санхүүгийн байгууллагатай өрсөлдөх бус, хамтарч ажиллах нь илүү үр дүнтэй гэдэг нь батлагдсан билээ. “Финтек бол банкнаас тусдаа ойлголт биш. Харин ч технологи, банк санхүүгийн үйлчилгээний нэгдэл юм” хэмээн GrapeCity Mongolia компанийн ерөнхийлөгч Б.Мөнхцэцэг ярьж байна. Тус компанийн хувьд банк санхүүгийн суурь бүртгэлийн систем, автоматжуулалтын систем хөгжүүлж, финтек буюу төлбөр тооцоог дижиталчлах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ба олон жилийн турш хөгжүүлж, шинэчилж ирсэн шийдлээрээ олон улсын зах зээлд гарахаар идэвхтэй эрэл хайгуул хийж буй. Энэ хүрээнд тэд Сингапурын AIDAS групптэй хамтран үйлчилгээ, платформоо Зүүн Өмнөд Азийн улсуудад нэвтрүүлэхээр хамтын ажиллагааны гэрээ байгуулаад байгаа юм. Хэрэглэгчид GrapeCity Mongolia-ийн хөрөнгө оруулалтаар байгуулагдсан

дэмжлэг үзүүлж буй. “Банкууд өөрийн гэсэн мэдээллийн технологийн нэгжтэй байхад яагаад финтекүүд үйл ажиллагаа явуулаад байдаг юм бэ?” гэж хүмүүс гайхдаг. Банк бүр тусдаа нэгжтэй байх нь зардал өндөртэй. Харин олон банкны дунд бид нэг л үйлчилгээ үзүүлж байгаа учраас хямд тусна гэсэн үг. Үүгээрээ л ялгаатай. Банк өөрөө томоохон дэд бүтэц буюу зам болж байна гэсэн үг. Харин финтекүүд тэрхүү замаар ачааг нь зөөж өгч байна. Энэ нь эцсийн хэрэглэгчтэй харилцах банкны зардлыг бууруулж байгаа юм” хэмээн Qrau үйлчилгээг хамтран үүсгэн байгуулагч Д.Даваа өгүүлж байна. Банкны дэд бүтэц суурилсан Qrau үйлчилгээ 2017 оны нэгдүгээр сараас зах зээлд нэвтэрсэн ба нийт хэрэглэгчдэд хүрэх банкны үйлчилгээг бага багаар сайжруулж буй. Тэд анх дансны нэр, дугаар, утгыг гарнаас бичиж оруулах шаардлагагүй болгож байсан бол одоо нэхэмжлэлийн мэдээллийг Qrau-ээр дамжуулах боломжтой болжээ. Монголбанкны статистик

хамтран хөгжүүлсэн Social-Pay аппликэйшн юм. Энэхүү аппликэйшн хэрэглэгчдэд мөнгө илгээх, хүлээн авах, нэхэмжлэх үйлчилгээг хэдхэн секундэд авах боломжийг бүрдүүлсэн билээ. Өмнө нь мөнгө шилжүүлэхдээ дансны дугаар, эзэмшигчийн нэр, гүйлгээний утга гэх зэрэг олон зүйлийг бөглөдөг байсан бол одоо тухайн хүний утасны дугаар, и-мэйл, социал хаягийн аль нэгийг мэдэж байхад л SocialPay-ээр гүйлгээ хийгдэх юм. Зээлийн үйлчилгээ үзүүлэгч финтек компани ч манай улсад үйл ажиллагаа явуулж байна. 50 мянгаас хоёр сая төгрөг хүртэлх зээлийг LendMN аппликэйшнээрээ дамжуулан олгодог And Global компани өнөөг хүртэл нийт 45 сая ам.доллар (ойролцоогоор 115 тэрбум төгрөг) –ын зээлийг хэрэглэгчдэдээ хүргэжээ. Тус компани үйл ажиллагаагаа Зүүн Азийн зах зээлд тэлэхээр төлөвлөөд буй. Монголд одоогоор LendMN аппликэйшнийг гар утсандаа татсан хүний тоо 300 мянга, эдгээрээс идэвхтэй

дэх аж. Цаашлаад And Global даатгалын салбарт нэвтрэх зорилготой гэдгээ илэрхийллээ. Өдгөө Монголд даатгалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг финтек хараахан үгүй билээ. Финтек компаниуд хэрэглэгчдэд ашиглахад хялбар үйлчилгээг хүргээд зогсохгүй бизнесийн бусад үйл ажиллагаанд ч эергээр нөлөөлөх болжээ. Тухайлбал, Qrau үйлчилгээ зах зээлд нэвтэрснээр trade.mn вэбсайтын ажиллагааг үлэмж хялбарчилсан байна. Мөн ICT Expo-2018-ын шилдэг үйлчилгээгээр шалгарсан SmartCar тээврийн хэрэгслийн үйлчилгээгээр хийгдэж буй нийт гүйлгээний 90 гаруй хувь нь Qrau-ээр дамждаг. “Хэрэв уламжлалт байдлаар төлбөр тооцоогоо шийдээд явсан бол тээврийн энэ үйлчилгээ амжилтад хүрэхгүй байсан болов уу” хэмээн Qrau-ийн хамтран үүсгэн байгуулагч Б.Чулуунсүх хэллээ. Монголын финтек компаниуд эцсийн хэрэглэгч хамгийн чухал гэдэгтэй санал нэгдэж байв. Гэхдээ тэд эцсийн хэрэглэгчээс





ТА ЯГ ОДОО ЗАХИАЛ

УТАС: 77074646

байна. Өнгөрсөн оны наймдугаар сарын байдлаар Америкт 5686, Европ, Ойрх Дорнодын орнуудад нийт 3581, Ази, Номхон далайн орнуудад 2864 финтек компани үйл ажиллагаа явуулж буй гэсэн судалгааг statista.com танилцуулжээ. Дэлхийн зах зээлийн чиг хандлагыг ажиглавал хөрөнгө оруулагчид ч финтек старт-апуудыг санхүүжүүлэх нь улам бүр нэмэгдсээр байгаа юм. KPMG-ийн судалгаагаар 2018 оны эхний хагаст финтек салбарт нийт 875 хэлцэл амжилттай явагдаж, 57.9 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ. Нарийвчилбал, хөрөнгө оруулагчдын сонирхол хиймэл оюун ухаанаас автоматжуулалт, даатгалын технологи хүртэлх өргөн хүрээг хамарсан байна. Энэ хүрээнд банкны дансгүй ч ухаалаг гар устай, социал медиа идэвхтэй ашигладаг хүмүүст зориулсан дижитал банкны үйлчилгээ үзүүлэгч Бразилын “Nubank” гэхэд л юникорн (нэг тэрбум ба түүнээс дээш ам.долларын үнэлгээтэй компани)-ын статуст хүрсэн бол Европ тивд Англи, Герман, Франц, Голланд, Швейцар улсын компаниуд хамгийн өндөр дүнтэй хэлцлийг хийжээ. Харин Азийн финтек зах зээлд Хятад (Alipay, WeChat), Энэтхэг (Paytm, Lendingkart) улс ноёрхож байгаа юм. Үүнтэй зэрэгцэн эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлэгч Япон улс тэдний араас нэхэж, тус улсын онлайн трейдинг платформ хөгжүүлэгч Folio компани 63 сая ам.долларын санхүүжилт татсанаараа бүс нутагтаа цойлж эхлээд буй. Түүнчлэн технологийн ертөнцөд ихэнхдээ сонирхлоос гадуур үлддэг байсан Африкийн финтек

судалгаанд манай улсад дөрвөн сая төлбөрийн карт ашиглагдаж байгаагаас 1.4 сая нь идэвхтэй хэрэглэгддэг гэжээ. Энэ нь 2017 оны мөн үеийнхээс 43.1 хувиар өссөн үзүүлэлт юм. Өнөө цагт хүмүүс бэлэн мөнгөнөөс татгалзаж аль болох аюулгүй, хэрэглэхэд хялбар төлбөрийн систем сонгох болсныг дээрх баримт илтгэнэ. Эхлээд бэлэн мөнгө, дараа нь төлбөрийн карт, харин одоо хүмүүс дижитал байдлаар төлбөр тооцоогоо шийдэхийг эрмэлзэх болсон юм. Энэ бол технологийн ачаар Монголд төдийгүй дэлхий даяар өрнөж буй бүтээлч устгалын үр дүн. Дэлхийн түвшинд харвал энэхүү устгал төлбөр тооцоо, зээл, мөнгөн шилжүүлгийн үйлчилгээг хялбарчлаад зогсохгүй нягтлан бодох бүртгэлийн систем, даатгал, краудфандинг, блокчэйн, цахим мөнгө, мэдээллийн аюулгүй байдлын технологи, өрхийн болон хөрөнгө оруулалтын менежмент зэрэг санхүүгийн олон чиглэлийн үйлчилгээг хамарчээ. Гэхдээ төлбөр тооцоо, зээлийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд хөрөнгө оруулалтын дүнгээрээ олон улсад илүүрхэж байна. Тухайлбал, 2018 оны тавдугаар сарын байдлаар хөрөнгө оруулалт татсан Азийн нийт финтек компаниудын 23 хувь нь зээлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ба тэд 191 сая ам.долларын хөрөнгө оруулалт авсан бол төлбөр тооцооны фирмүүдийн хувьд энэ тоо 133 саяар хэмжигджээ. Финтек компаниуд уламжлалт санхүүгийн байгууллагуудтай өрсөлдөж, зах зээлээс шахна гэсэн таамаг олон нийтийн дунд байдаг ч энэ талаар эдгээр

Most Fintech компанийн Most Money үйлчилгээгээр тэднийг илүү сайн мэднэ. Энэхүү үйлчилгээ 2012 онд зах зээлд амжилттай нэвтрэснээс хойш Most Money аппликэйшнийг татсан хэрэглэгчдийн тоо 300 мянга гаруйд, харин идэвхтэй хэрэглэгчийн тоо 120 мянгад хүрээд байна. Картын хэрэглээг багасгаж буй Most Money үйлчилгээнд таван банк, банк бус санхүүгийн долоон байгууллага, худалдаа, үйлчилгээний 180 мянган байгууллага мөн нэгд-жээ. Эндээс банкуудад бүтээг-дхүүн, үйлчилгээгээ хялбар-шуулж, дижиталчлах боломжийг финтек олгож байгааг анзаарч болно. PwC компаниас санхүү-гийн байгууллагууд ойрын 3-5 жилийн дотор финтектэй хамтын ажиллагаагаа 82 хүртэл хувиар өсгөнө гэж таамаглажээ. Өнгөр-сөн онд тус компани 71 улсын санхүүгийн салбарын 1300 гаруй ахлах ажилтан болон удирдах түвшний албан тушаалтныг хамруулсан судалгаа явуулахад тэдний 45 хувь нь финтек компаниудтай хамтарч байгаа гэсэн нь 2016 оныхоос 32 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин The Economist Intelligence-ийн олон улсын хэмжээнд хийсэн судалгаагаар банкууд болон финтек фирмүүдийн бараг тал хувь нь эдгээр хоёр төрлийн байгууллагын хамтын ажиллагаа, үйл ажиллагааны нэгдэл нээлттэй ханддаг хэмээн хариулсан байна. Дижитал үйлчилгээний хөг-жилтэй зэрэгцэн уламжлалт банкууд финтек компаниудын потенциалыг ухаалгаар өсгөх болжээ. Тухайлбал, Африкийн Escobank дэргэдээ финтекүүдэд зориулсан хөтөлбөр хэрэгжүүлж, ирээдүйтэй компаниудад

мэдээллээр Монгол орон даяар 800 мянга гаруй интернэт банк хэрэглэгч бүртгэлтэй байсан ба тэдгээрийн тал хувь нь идэвхтэй хэрэглэгчдийн тоонд багтсан байна. Харин өнгөрсөн жилийн тухайд идэвхтэй хэрэглэгчдийн тоо 800 мянгад хүрчээ. Товчхондоо, хэрэглэгчийн бэлэн байдал хангагдсан гэсэн үг. Д.Даваа “Асуудлууд нүүрэн талд биш, ардаа байна. Шинэ үеийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүртээмжтэй байлгахын тулд банк болон финтек илүү сайн интеграцид орох ёстой. Банкууд финтектэй ямар чиглэлээр, хэрхэн хамтрах бодлогоо тодорхойлж, мэдээллээ хэрхэн солилцох, мөн хамгаалах, финтект ямар шаардлагууд тавихаа тодорхой болгох шаардлагатай. Юун түрүүнд энэ бүхнийг тодорхой болгох нь чухал” хэмээн онцоллоо. Монголд банк, финтек хамтран амжилтад хүрсэн өөр нэг жишээ бол Голомт банк “Хязгааргүй шийдэл” финтек компанитай

хэрэглэгчдийнх нь тоо 75 мянгад хүрээд байгаа юм. “Хөгжиж буй Мьянмар, Филиппин зэрэг улсад Viber их ашигладаг. Мьянмарт л гэхэд 40 сая гаруй хэрэглэгчтэй. Эдгээр улсын зах зээлд нэвтрэхийг зорьж буй манай компанийн хувьд Viber-аар дамжуулан үйлчилгээгээ хүргэвэл олон талын ач холбог-долтой. Тиймээс ч бид Viber-ийг 2014 онд худалдан авсан Японы Rakuten компанитай шат шатны хэлцэл хийж байна. Цаашлаад And Global компани маань Монголдоо Viber ашиг-лан үйлчилгээгээ хүргэх болно” хэмээн тус компанийн үйл ажил-лагаа хариуцсан дэд ерөнхийлөгч В.Баярсайхан ярилаа. Тэд Lend Wallet технологийг танилцуулаад буй. Энэхүү үйлчилгээг зөвхөн зээл авах бус, өөр олон зорилгоор ашиглах боломжтой. Тухайлбал, төлбөрөө хэд хэдэн сонголттойгоор төлөх, мөнгөн гуйвуулга хийх зэрэг үйлчилгээг тогтсон жишгээс хямд, хялбархан байдлаар ший-

гадна байгууллагууд руу чиг-лэсэн үйлчилгээнд аль хэдийн анхаарал хандуулаад эхэлжээ. Ингэснээр байгууллагууд хэрэглэгчдэдээ финтекүүд эцсийн хувь хэрэглэгчид санал болгож байгаа шиг хялбар байдлаар үйлчилгээгээ хүргэх төдийгүй үйл ажиллагаа нь илүү хялбар, зардал багатай болох ач холбогдолтой. Финтек компаниудын бас нэг санал нэгдсэн зүйл нь шинээр бизнес эхлүүлж буй хүмүүс том асуудлыг бүхэлд нь шийдэхийг зорьж, нэг л том алхахыг хүсдэг нь учир дутагдалтай гэлээ. Гэтэл том зах зээлтэй гаднын улсуудад финтек компани зөвхөн сонгож авсан жижиг алхмаа л сайж-руулдаг нь эргээд сайн үйлчилгээ болж нэвтэрч чаддаг байна. Үүнтэй адил аливаа үйлчилгээг бага багаар сайжруулах зарчмаар явах нь оновчтой аж. Харин хэрэглэгчдийн хувьд энэ бүхэнд аажим аажмаар суралцаж байгаа нь зах зээл улам бүр өргөжихөд нөлөөлж байна. 📞



Дэлхийн хэмжээнд нийт харилцагчдын 50 гаруй хувь нь хамгийн багадаа нэг финтек компаниар үйлчлүүлдэг. Харин финтек компанийн харилцагчдын 64 хувь нь бүхий л хэрэгцээнээ дижитал суваг ашиглахыг илүүд үздэг аж. Технологийн өндөр мэдлэгтэй харилцагчдын 67.3 хувь нь санхүүгийн технологийн компаниудын үйлчилгээг авдаг юм байна.

ХАРИЛЦАГЧИД ФИНТЕКИЙГ ХЭРХЭН АШИГЛАДАГ ВЭ		
МӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ		68%
ТӨЛБӨР ТӨЛӨХ		84%
ХУВЬ ЗЭЭЛ		56%
ХУВИЙН САНХҮҮГИЙН МЕНЕЖМЕНТ		60%
УЛАМЖЛАЛТ ХАДГАЛАМЖ/ХАДГАЛАМЖИЙН ДАНС		49%
ДААТГАЛ		38%

MSE warns to delist firms in case of failure to submit reports

LendMN NBFi to cooperate with Transfer To Inc for an international transaction service.

Temporary ban on child services in place

Entities are prohibited to serve children aged between 0-10 until flu outbreak eases.

Bill on Investment Bank remain undiscussed since 2016

The bill will allow foreign banks to invest in major projects and programs.

Top 20 Index decreases 0.32 percent, to 21,631.07 points

Market cap stands at MNT 2.47 trillion.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS


Mongolia signs Memorandum of Understanding with Engineers India Ltd, a PSU under the Ministry of Petroleum and Natural Gas of India, through Mongol Refinery State Owned LLC on the sidelines of PETROTECH-2019 event at Greater Noida, India. The MoU is for Project Management Consultancy services for construction of an oil refinery plant in Mongolia by EIL.

ECONOMY

Mongol Basalt JSC announces to distribute MNT 1 per share of dividends this year.

MIAT Airlines plans to purchase four 737 MAX 8s. All four aircraft are expected to be delivered by the end of 2020 and the first delivery was recently completed. Aircraft will be used to boost air transport and tourism as a new airport is scheduled to open near the end of the second quarter.

Top 20 Index decreases 0.32 percent, to 21,631.07 points. MSE A Index grows 0.66 percent, to 9,875.19 points. MSE B Index falls 0.75 percent, to 8,403.77 points. Market cap stands at MNT 2.47 trillion.



SOCIETY

Ulaanbaatar Winter Festival 2019 to take place on February 16-17 at the Sky Resort.

MNT 400 million allocated for the protection and development of Ugii lake of Arkhangai province in 2019-2020.

Bank of Mongolia to issue commemorative gold coin Mazaalai with a millesimal fineness of 999 and a face value of MNT 1000.

Mongolian judokas win a silver and bronze medals from Paris Grand Slam 2019.

MSE warns to delist firms that fail to deliver reports

LendMN NBFi plans to introduce international transaction service

Tugsbilig.B @tugsbiligZGM

In order to improve the transparency in the financial market, Altai Khangai, CEO of the MSE, warns to delist publicly traded firms in case of failure to deliver financial and operational reports.

On the list of firms with good governance, the recent IPOs are at the forefront; for example, LendMN JSC was the first company to turn in their 2018 financial and operational reports. The company earned a net profit of MNT 2.5 billion last year, making it possible for the company to distribute dividends this year. Additionally, the company recently announced to introduce an international transaction service by co-operating with “Transfer To” inc. According to Marketinfo, the board of LendMN has approved the CEO to sign MNT 1.4 billion worth deal with Transfer To.

Also, the MSE Tier-II listed company Mongol Savkhi JSC’s sales revenue totaled MNT 270 million in 2018, which is about 9.4 percent lower than the previous year. The stock price of the company, which



CEO of Mongolian Stock Exchange highlights the improving transparency of publicly traded firms.

Batsaikhan.S / ZGM©

manufactures leather and felt products, stood at MNT 480 per share as of February 2, which is a 50 percent fall year over year.

The net loss of the state-owned Darkhan Thermal Power Plant JSC reduced to MNT 1.8 billion last year. This is about 25 percent lower than in 2017. The 2018 financial report of the company shows that

the cut in losses was mostly driven by the reduced foreign exchange losses.


Last year, a total of 130 MSE-listed firms have disclosed their financial and operational reports. The remaining 80 companies did not share their financial information to shareholders. Thus, in order to protect the investors’ rights, the

MSE has warned to delist publicly traded companies that failed to disclose their reports or organize shareholders’ meetings.

In January, the market capitalization of the MSE diminished by 2.53 percent (MNT 63.5 billion), to MNT 2.4 trillion with the Top 20 Index growing 0.43 percent. Specifically, stock trades accounted for 97 per-

cent of total trades and securities - 3 percent. Compared to January 2018, stock trades jumped by 5 times and securities trade was cut by 45 times. While the new IPOs had the biggest impact on stock trades, the suspension of Government securities trades at the primary market resulted in inactivity in the overall securities market. [ZGM]

STOCK MARKET



SOCIETY



Municipality temporarily bans entities from serving children aged 0-10

In connection with the beginning of the third academic quarter, the acting Mayor of Ulaanbaatar City Batbayasgalan Jantsan issued an order to temporarily suspend public services for children, with the exemption of kindergartens.

Although the pressure has eased and hospitals are no longer overcrowded with children suffering from influenza and the common cold, the Municipality is taking

preventive measure against the cold weather and the lingering outbreak of swine flu that is posing an increased risk for children with the start of the academic quarter.

For instance, playgrounds, internet cafes, movie theatres, entertainment, restaurant, and public dinners are ordered not to serve children aged between 0 and 10. Entities that neglected the order will be charged MNT 1 million

and the parents will be charged MNT 100,000.

Additionally, over 200 accidents were reported during the lunar new year as of February 7. Due to the cold weather and snow storm, several people were reported with frostbites according to the Ulaanbaatar City Health Department. Officials warned to avoid traveling long distance on vehicles in the upcoming days. [ZGM]

POLITICS

Delay in investment bank bill scares away foreign banks

Batbukh.P, Tugsbilig.B ZGM

Parliament is yet to discuss the bill on Investment Bank, which was submitted in 2016 by MPs Javkhlan Bold, Batzorig Batjargal and Undarmaa Batbayar. The bill was a priority on the Parliament’s order list at the time as it states to develop the legal environment of drawing foreign direct investment (FDI) and allow multinational banks to establish their branches in Mongolia to improve transparency in the banking and financial system.

The initiator of the bill, MP Javkhlan addressed, “It seems that foreign banks are losing interest before the ratification of the bill. I am afraid there will not be many banks interested in investing in Mongolia with the current economic state. At the time of the submission of this bill, foreign banks were highly interested in Mongolia. But I am not sure if the ratification of the bill will be as effective at present.”

He expressed that the draft law has already lost its momentum and

remain in a deadlock. “But the approval of the law will be a significant step for the development of the financial market,” noted Mr. Javkhlan.

Bill on Investment Bank remains undiscussed three years after submission

Mongolia accepted the obligation to open its financial market when it joined the World Trade Organization in 1997. As a result, various foreign banks started operating in Mongolia since 2008. Furthermore, three out of 14 commercial banks operating in Mongolia currently have foreign stakeholders. But the current regulations lack the liberty to allow foreign investment banks to independently operate in the country. The initiators expect the

bill to increase competition and productivity in the banking and financial sector, help reduce the interest rate, adapt to new technology, install good practice and know-how, cut non-performing loans and boost access to loans.

The law will enable the Bank of Mongolia to grant foreign banks the permissions to invest in major projects and programs. In other words, the bill will not allow them to provide commercial loans and savings services.

Furthermore, the draft bill requires the foreign bank in question to have a delegation in Mongolia for over a year prior to issuing the request. The minimum assets must be no less than MNT 500 billion. Considering the fact that the average assets of commercial banks in Mongolia are around MNT 800 billion to MNT 1.5 trillion, officials expect the threshold to be revised. Additionally, the draft obliges the foreign bank to have at least one Mongolian to be among the board, who will be appointed from the National Security Council to monitor its operations. [ZGM]

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР



- 07:00“Өглөө” хөтөлбөр/ шууд/
- 10:00“Соёл эрдэнэ” хөтөлбөр
- 14:00Туульсийн хаан Жангар: “Хэлмэрч Хээ Жилганы бөлөг”
- 15:30Хөгжлийн замаар: “Оюутны дотуур байрны үйлчилгээ”
- 19:35Судар бичгийн алтан сан: “Модон барын уламжлал”
- 21:10“Цаг үе, үзэл бодол” Д.Жавзандорж Гэвш, лхаарамба

Bloomberg TV Mongolia

- 07:00“Бүрэн тайлбар” нэвтрүүлэг
- 09:00“Бизнесийн хэмнэл” хөтөлбөр
- 11:00“Сая долларын суутан” нэвтрүүлэг
- 17:00“Bloomberg Technology” “Мөнгөний урсгал” хөтөлбөр
- 22:30“Хариуцлага ба үнэ цэнэ” нэвтрүүлэг

БОЛОВСРОЛ

- 07:05“Бяцхан оцон шувуу Пороро” хүүхэлдэйн кино 4.5-8-р анги
- 09:00“Шидтэнүүдийн клуб” хүүхэлдэйн кино 6.15-16-р анги
- 11:25“Хөгжилтэй Монголдой” 3-р ангийн хичээл №5
- 14:10Хөгжих үү? Залуус аа
- 19:00“Надтай гэрлээч” СОАК 31-р анги
- 21:00“Мөнгөтэй зочин” шоу нэвтрүүлэг

МОНГОЛTV

- 06:30“Тог тог тог” /season-7/ 26-р хэсэг
- 10:00“Макс Стил хоёр” хүүхэлдэйн кино 19-р анги
- 12:30“Манай гэр бүл” Туркийн ОАК 13-р анги
- 16:00“Тахианы өд” ОАК 51-р анги
- 19:00“Оргил цаг” мэдээллийн хөтөлбөр
- 01:30“Намайг сонгооч” 12-2-р хэсэг

ЗУРХАЙ



Билгийн тооллын 7
Хаврын тэргүүн улаан бар сарын гурван хөх мэнгэтэй, цагаан луу өдөр
Үс засуулбал: Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ
Наран ургах, шингэх: 08.01-18.09
Барилдлага: Арвидах
Шүтэн барилдлага: Авахуй
Суудал: Гал

Аргын тооллын хоёрдугаар сарын 12, Ангараг гар.
Билгийн тооллын 7, Гоё хүүхэн одтой, цагаан луу өдөр.
Өдрийн наран 08.01 цагт мандан, 18.09 цагт жаргана. Тухайн өдөр хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, лус тахих, бороо хур оруулах, ээтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод хошой мөрөө гаргавал зохистой.

ОНЦЛОХ ҮЗВЭР


НАСАН ТУРШДАА



Coaching Wednesday
Хэзээ: 2019.02.13-ны 12.00 цагт
Хаана: The Corporate Hotel&Conven
Тасалбарын үнэ: ₮10 мянга



Turuu&Sally Best Love songs live concert
Хаана: АСА цирк
Хэзээ: 2019.02.14-ний 20.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 20-40 мянга



“Ромео, Жульетта” жүжиг
Хаана: УДЭТ
Хэзээ: 2019.02.14-15-нд 14.00, 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮10-30 мянга

Нөхөртөө хаягдсан Сувдаа бүсгүй бүх зүйлээс өөрийгөө холдуулж, гэртээ шаналан өдөр хоногийг өнгөрүүлнэ. Гэтэл 20 жилийн өмнө Сувдаагийн араас гүйдэг байсан анхны хайр болох Дэлгэр түүн рүү залгаж, одоог хүртэл ганц бие байгаагаа мэдэлцнэ. Ингээд тэд болзохоор болж, Сувдаа амьдралаа шинээр эхлэхээр шийднэ. Гэвч болзоонд

ирсэн Дэлгэр Сувдаагийн хүлээж байсан Дэлгэрээс тэс өөр байх аж. Сувдаа дахин хүнд цохилтонд орлоо. Яг энэ үед хажуу айлын Самдан гэх олон жил ганц бие яваа эр Сувдаад гэрлэх санал тавина. Харин анхны хайраа харсан Дэлгэр Самданд бууж өгөхгүй гэж Сувдаад хайраа илчилнэ. Энэхүү хайрын тулаанд хэн нь ялах бол?

Найруулагч Р.Эрхэмбүрэнгийн бүтээл “Насан туршдаа” инээдмийн уран сайхны кино хоёрдугаар сарын 8-наас “Өргөө” кино театрын дэлгэцнээ гарч эхэллээ. Киноны гол дүрд А.Баттүшиг, Ш.Доржсүрэн, Т.Нямдорж, Б.Одончимэг нар тоглож, Д.Хүрэлхүү продюссероор нь ажиллажээ. [ЗГМ]

ЦАГ АГААР

УЛААНБААТАР




ФОТО АГШИН



Эзэн Чингисийн өлгий нутагт эрх дураараа амьдарна аа.

Б.Хасуй / ЗГМӨ

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

1	2	3	4	5	6	7	8
9				10			11
	12	13			14		16
15						16	
	17			18	19		21
20							

БОСООГООР.

- Анхдугаар Богд өндөр гэгээний эзэгч
- Жижиг мэрэгч амьтан
- Нийслэлийн нэгэн дүүргийн товчилсон нэр
- Анхдагчдын

- өлгий гэгдсэн аймаг
- Импортын тамхи
- Солонгосын томоохон телевиз
- Сагсан бөмбөгийн багаараа

- монголчуудын хэзээний танил болсон АНУ-ын нэгэн муж
- Амьтан барих хэрэгсэл
- Монголд анхны олимпын аваргыг төрүүлсэн

- спортын төрөл
- Эгшиг
- Бурханы гэргий

ХӨНДЛӨНГӨӨР:

- Тэнгэрийн өнгө
- Саяхан албан тушаалаасаа чөлөөлөгдсөн улстөрч

- Хамгийн олон хүн амтай тив
- Дэлхийн хамгийн урт мөрөн гол
- Туялзуур жад
- Илэрхий гэсэн утга
- Бууны эд анги
- Орц найрлага
- Даалуугаар тоглодог

- тоглоом
- Буриадын нэгэн овог
- “Үхэрчин хүү” дууг зохиосон нэрт соён гэгээрүүлэгч
- Баатар ван
- Дэлхийн топ багуудад тоглон гялалзаж асан алдарт

- хөлбөмбөгчин, өдгөө Либерии улсын Ерөнхийлөгч
- Зэлэн ургах жимст ургамлын нийтлэг нэр

ТАШУУГААР:

- Архины жүнз
- Зөвлөлтийн нэрт зохиолч

Н	Ү	Х	Т	И	Г	О	Н	Ь	И	Л	Х	А	М
А		А		И		Р		Г		А		А	
М	А	Д	А	Г		Э	О	Д	Б	Я	Л	А	Р
И	А	О	Г	Д	Ж	И	Б	З	У	Н	Д	А	М
Б	О	Г	Д	Ж	И	Б	З	У	Н	Д	А	М	Б
			У		З			А		О			
			Г		А		Н	Д	И	И	М	О	

Өмнөх дугаарын хариу / 02.11

ЗГМ: СУДОКУ

8			9				
4					8		
						5	6
						3	5
		7	6			9	
		6					7
		2			5		
3				8			4
9			7				6
						7	

1	2	3	9	4	8	5	6	7
6	9	5	7	1	2	3	4	8
7	8	4	6	3	5	9	2	1
5	1	6	2	8	3	7	9	4
2	3	9	5	7	4	8	1	6
8	4	7	1	6	9	2	5	3
4	6	2	3	9	7	1	8	5
3	5	1	8	2	6	4	7	9
9	7	8	4	5	1	6	3	2

(Өмнөх дугаарын хариу)



ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

ЭРЭЭН-УБ	18.00	11.15
УБ-ХӨХ ХОТ	20.00	20.49
ХӨХ ХОТ-УБ	22.50	11.15
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-СҮХБААТАР	21.15	05.12
СҮХБААТАР-УБ	20.55	05.03
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48
УБ-ЗАМЫН-ҮҮД	17.20	07.05
ЗАМЫН-ҮҮД-УБ	17.35	08.55



НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-БЭЭЖИН	17.15	19.30
БЭЭЖИН-УБ	20.30	23.00
УБ-ХОНКОНГ	07.50	12.25
ХОНКОНГ-УБ	13.25	18.05
УБ-СӨҮЛ	07.45	12.05
СӨҮЛ-УБ	13.20	16.05
УБ-ТОКИО	08.55	14.30
ТОКИО-УБ	15.30	20.25
УБ-ХӨХ ХОТ	10.30	12.00
ХӨХ ХОТ-УБ	13.00	14.40
УБ-ЭРХҮҮ	06.20	07.20
ЭРХҮҮ-УБ	08.20	09.20

ЭДИЙН ЗАСАГ

Car sharing-ийн ирээдүй автомашин үйлдвэрлэгчдэд халгаатай

Автомашины нийт зах зээлийг үндсээр нь өөрчлөх тэрхүү цэгт ойртож байна.

> 10




Alphabet-ын туршилтын салбар опиоид тахалтай тэмцэнэ

Опиоидын тун хэтрүүлснээс үүдэлтэй үхлийн тоогоор тэргүүлж буй гол таван муж улсын нэг нь Охайо.

> 10

Хятадын шинэ оны гараа- шинэ эрсдэл

Хятадын хөрөнгийн зах зээлийн индекс хуучны өсөлттэй үе төгсгөл болсныг зааж эхлэв



Bloomberg®

“Муугаар төсөөлбөл худалдааны яриа хэлэлцээ шууд тасалдаг болзошгүй” хэмээн Дэвид Хонер зэрэг Bank of America-гийн стратегичид хоёрдугаар сарын 7-нд анхаарууллаа. “Яриа хэлэлцээ итгэл төрүүлж чадахааргүй бүрхэг болж өнгөрөх, эс бөгөөс хоёрдугаар сарын 28-наас тогтоосон эцсийн хугацааг дахиад сунгах тохиолдолд тодорхой бус нөхцөл үүргэлжлэхээс аргагүйд хүрнэ.

Хоёрдугаар сар хөгжиж буй зах зээл төдийгүй дэлхий нийтэд эрсдэлтэй өнгөрөх нь”.

Хятадын Ардын Банк буюу БНХАУ-ын төв банк юанийн ханшид өөрчлөлт оруулах асуудал д даваа гарагаас анхаарлын төвд орж ирнэ. Төв банк юанийн оншор буюу дотоодын ханшийг оффшор ханштай уялдуулан сулруулж болзошгүй. Эсвэл валютата дэмжих үүднээс ханшийг нь хатуу бариулах арга ч хэрэглэж болзошгүй. Өнгөрсөн

Нэгдүгээр
сард өссөн
Хятадын
голлох
индексүүд
билгийн
тооллын
шинэ оны
амралт
дууссанаас
хойш суларч
болзошгүй.



долоо хоногт арилжаачид ам.долларын ханш чангарсаар байгаатай уялдан оффшор юанийг их хэмжээгээр зарлаа. Оффшор юанийн ханш өмнө нь нэгдүгээр сард өссөн юм.

Он гарсаар бараг 380 тэрбум ам.доллараар сэргээд байгаа Хятадын үнэт цаасны зах зээлд ирэх хэдэн долоо хоног эргэлтийн үе болох төлөвтэйг статистик үзүүлэлт гэрчилж байна. Хятадын CSI 300 индекс нэгдүгээр сараас хойш, билгийн тооллын сар шинийн амралтаас өмнө үнэмлэхүй өссөн.

Shanghai Composite Index ч өнгөрсөн оны хоёрдугаар сараас хойш анх удаа 100 хонгогийн дунджаасаа дээш үзүүлэлттэй хаагдсан. Хонконгийн Hang Seng индекс 28 мянга гэсэн суурь үзүүлэлттэй байлаа. Баасан гаргат Хонконгийн Hang Seng China Enterprises индекс 0.7 хувийн бууралттай хаагдаж өмнөх алдагдал 2.2 хувиь болгон өсгөв. Яриа хэлэлцээнд ахиц гарвал Трамп шийдвэр гаргах эцсийн хугацааг уртасгаж таарна гэсэн таамагт төлөгдсөн юунийн ханш бараг өөрчлөгдсөнгүй.

Хоёр тал “хожим” уулзах болов уу хэмээн АНУ-ын Ерөнхийлөгч пүрэв гарагт сэтгүүлчдэд мэдэгдлээ. “Яриа хэлэлцээ үргэжлэнгээ эцсийн хугацааг сунгах л хамгийн болзошгүй хувилбар” хэмээн Danske Bank-ны тэргүүлэх шинжээч, Хятадын эдийн засагч Аллан фон Мерен тайлбарлав. “Эцсийн тохиролцоо дөхөх тусам зах зээлийн тогтворгүй нөхцөлд бүгд бэлэн байх шаардлагатай” хэмээн шинжээч өгүүлсэн юм.

Өрсөлдөөн Тайландын үүрэн холбооны үйлчилгээг эрс хямдруулна

Суттини Ювежваттана

Тав дахь үеийн сүлжээнд аварга хөрөнгө хаяж буй компаниудын ширүүн өрсөлдөөний үр дүнд Тайландад ирэх хэдэн жилийн турш үүрэн холбооны үйлчилгээний үнэ эрс буурна хэмээн Telenor ASA-гийн дэмжлэгтэй Total Access Communication компани тооцоолж байна. Зах зээлд эзлэх байр сууриа алдахгүйн төлөөх ширүүн тэмцлийн улмаас Total Access Communication-ы орлого 14 улирал дараалан буурчээ.

Тайландын эрх баригчид энэ онд явуулахаар товлосон 5G сүлжээний эрхийн худалдаанд Total Access бэлэн бус байгааг тус компанийн гүйцэтгэх захирал Александра Рэйх мэдэгдэв.

Лондон-Сиднейн анхны шууд нислэг

Кристофер Жаспер

Boeing, Airbus-ын 17 мянган километрийн зай туулах чадвартай тийрэлтэт онгоцнууд бараг бэлэн болж буйтай уялдан Qantas Airways компани Сиднейгээс Лондон руу анхны шууд нислэг үйлдэх мөч ойртсоор байна.

Qantas нь Австралийн гол том хотуудаас Лондон, Парис, Нью-Йорк хүрэх 20 орчим цагийн алсын нислэгийн шинэ чиглэл үүсгэх төлөвлөгөөтэй. Төлөвлөгөө амжилттай хэрэгжвэл тус компанийн Лондон-Оклендын чиглэл шууд нислэгийн уртаараа дэлхийд шинэ дээд амжилт тогтоох юм. Singapore Airlines компаниас Сингапур, Нью-Йоркийн хооронд үйлддэг 16 мянган километрийн нислэг одоогоор дэлхийн хамгийн алсын шууд нислэг болдог.

Газрын тосны нийлүүлэлт буурах төлөвтэй

Жулиан Ли

Дэлхийн бөмбөрцгийн умард хагаст өвөл үргэлжилж байвал ичээндээ унтаж буй баавгай бус, газрын тосны буй ноёрхдог. Гэтэл ОПЕК олборлолтоо бууруулж, АНУ-ын хориг үйлчлэх тусам газрын тосны эрэлт өснө гэсэн хөөрөл намжих хэрээр шинэ жилийн үеэр эрчээ авсан үнийн өсөлт эргээд буурах төлөвтэй боллоо.

Саудын Араб ОПЕК-той хийсэн тохиролцоогортоо хүлээсэн хэмжээгээр олборлолтоо бүр 12 дугаар сард бууруулсан төдийгүй нэгдүгээр сард бууруулах ёстой хэмжээгээ давуулан биелүүлчихээд байгаа. АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп ОПЕК-ийн хоёр дахь гол олборлогч Венесуэлийн газрын тосонд хориг тавьсан нь нийлүүлэлтийг бүр ч хомс болгож таарна.

ОПЕК-оос АНУ-д нийлүүлдэг газрын тос нэгдүгээр сарын байллаар сүүлийн таван жилийн үнэмлэхүй доод түвшинд багассаныг ачаа тээврийн хяналт бүртгэлийн Kpler компанийн статистик баталж байна. Нефть тээвэрлэгч хөлгүүдийн ачаа тээврийг бүртгэдэг Bloomberg-ийн статистикаас харахад Персийн булангаас АНУ-д нийлүүлсэн газрын тос

12 дугаар сарынхаас 36 хувь, өнгөрсөн оны наймдугаар сарынхаас бүр 60 хувь багассан дүнтэй байгаа юм.

Саудын Арабаас АНУ-д нийлүүлдэг газрын тос ч ОПЕК-ийн тохиролцоо хэрэгжиж эхэлсэн 2017 оны нэгдүгээр сараас хойш үнэмлэхүй буурлаа. Харин АНУ-ын олборлолт өсөх эрч 2019 онд эрс суларна гэсэн тооцоотой ч эргэлзээ байсаар. Учир нь 2018 онын нэгдүгээр сард АНУ-ын олборлолтыг тооцохдоо зуны өсөлтийг урьдчилан харж чадаагүй.

АНУ-ын олборлолт 2017 оны 12 дугаар сараас 2018 оны 12 дугаар сар хүртэлх жилийн хугацаанд өдөрт бараг 1.8 сая баррелиар өссөн нь өнгөрсөн оны нэгдүгээр сард анх тооцоолсноос даруй гурав дахин их байгаа юм. Харин энэ онд тус улсын олборлогтыг өдөрт 520 мянган баррелиар өснө хэмээн тооцоолжээ. АНУ-ын олборлогтын өсөлт саарах нь газрын тосны үнэ өсөх нэг нөхцөл болно.

Хэт хүнд тосоо дамжуулах
хоолойгоор тээвэрлэхийн тулд
хөнгөн тостой хольдог Венесуэлд
Трампын хориг давхар цохилт
болж байна. Тус улс хүнд тосны
олборлолтоо хадгалж үлдэхийн
тулд хөнгөн тосны экспортоо ч
бууруулахаас аргагүй. Хориг арга

хэмжээний улмаас Венесуэлийн газрын тосны олборлолт улам багасаж таарна.

Газрын тосны нийлүүлэлт буурсаар байгаа ч эрэлт ихсэх төлөв муу хэвээр. Хятадын бараа бүтээгдэхүүнд илүү өндөр тариф тогтоох гуравдугаар сарын 1-нээс өмнө БНХАУ-ын дарга Ши Жиньпинтэй уулзахгүй хэмээн Дональд Трамп мэдэгдсэн нь хоёр улсын худалдааны яриа хэлэлцээ амжилттай урагшлах найдварыг багасгалаа. Европ бүсийн голлох улсуудын эдийн засгийн өсөлтийн урьдчилсан тооцоогоо бууруулж өөрчилсөн Европын Комисс цаашид Vrexit болон Хятадын удашрал байдлыг улам дордуулах төлөвтэйг анхааруулав. Эдийн засгийн хэтийн нөхцөл баргар хэдий ч энэ оны турш газрын тосны эрэлт тогтвортой байх төлөвтэй.

“Газрын тосны дундаж үнэ жилийн өмнөх үеийн түвшнээс доогуур байгаа”-г Олон Улсын Эрчим Хүчний Агентлаг (IEA) сарын өмнө мэдэгдсэн нь эрэлт тогтонги байхын дохио болж байна. Тус байгууллагаас лхагва гарагт гаргах шинэ тооцоо энэхүү байр суурь цаашид хүчин төгөлдөр үргэлжлэх эсэхийн шалгуур болно.

BSBМЕБЕЛЬ

ШИНЭ

**ОФФИС МЕБЕЛИЙН
ДЭЛГҮҮРИЙН НЭЭЛТИЙН
УРАМШУУЛАЛ**

**БҮХ БАРАА
БУСАД САЛБАРААС**

+3% ИЛҮҮ ХЯМД

A photograph of the BSB Office Furniture Showroom building. The building is a two-story structure with a blue upper floor and a yellow lower floor. It has several windows and a modern design. The BSB logo is visible on the building's facade. In front of the building, there is a blue banner with the BSB logo and the text 'ОФФИС МЕБЕЛИЙН ДЭЛГҮҮР' (Office Furniture Showroom). The background shows a clear blue sky.

☎ 7509-0272
f /bsbmebellic
www.bsb.mn

📍 Сүхбаатар дүүрэг 3-р хороо, Нарны зам дагуу
Урбанекийн баруун талд БСБ Оффис мебелийн дэлгүүр

Эдийн засаг

Car sharing-ийн ирээдүй автомашин үйлдвэрлэгчдэд халгаатай

Илья Хренников

Программ хангамжийн худалдаа эрхэлдэг, 31 настай Евгений Барков Моксвагийн гэрийн цонхоороо шинэхэн авсан машинаа дурамжхан ширтдэг ажилтай. Худалдаж авснаас хойших цаг хугацааны 90 хувьд нь шинэ унаа ашиглалтгүй, гадаа сойгоотой мөртөө байнга мөнгө салгах нь түүний унтууг хүргэнэ. Эцэст нь тэрбээр тооны машин гарган бүх зардлаа тооцоод үзтэл шинэ саарал Peugeot машинаа зараад, оронд нь Yandex.Drive гэх мэт car sharing үйлчилгээнд шилжих нь хавьгүй хэмнэлттэй гэсэн дүгнэлт гарлаа. Car sharing үйлчилгээнд даруухан Kia загвараас эхлээд ганган Porsche хүртэл бүх л унаа байгаа.

“Машин худалдаж авсан маань түвгээс цаашгүй” хэмээн өгүүлэх Барков эдүгээ Москвагийн цастай гудамжаар хажуу бөөрөндөө тод шар наалт, бүхээгийн хянах самбартаа Yandex-ын программ хангамж бүхий цагаан Skoda-гийн жолоо мушгиж явна. “Одоо бол би хэрэглээндээ л мөнгө төлж байгаа”.

ОХУ-ын интернэт үйлчилгээ эрхлэгчээс өнгөрсөн онд байгуулсан венчур компани нийслэл Москва хотод минут нь таван рубль буюу найман центийн түрээсийн хөлстэйгөөр 7,000 гаруй машин үйлчилгээнд нэвтрүүлжээ. Машины шатахуун, арчилгаа үйлчилгээ, зогсоолын төлбөрийг компани хариуцна. Daimler компаниас Нью-Йорк хотод нэвтрүүлсэн Car2Go үйлчилгээний минут нь 41



Yandex.Drive автомашин Москвад.

центийн үнэтэйг харгалзан үзэх юм бол Москвагийнханд сайхан боломж бүрдэж буй хэрэг. Москвад цоо шинээр үүссэн car sharing үйлчилгээний цар хүрээ хурдацтай тэлж зөвхөн 2018 онд машины тоо нь гурав дахин өслөө. Москва хот эдүгээ шеринг үйлчилгээний машины тоогоор Европ тивд тэргүүлж, дэлхийд хоёрдугаарт орж байна. Автомашин хувьдаа эзэмшдэг уламжлалт загварыг халаас томтой технологийн компани шуурхай өөрчилсөн нь автомашин үйлдвэрлэгч компаниудад хараал хийсэнтэй адил зүйл болов.

“Та бид автомашины нийт зах зээлийг үндсээр нь өөрчлөх тэрхүү цэгт ойртож байна” хэмээн Лондонд төвтэй Frost & Sullivan консалтингийн компанийн шинжээч Шветха Сурендер өгүүлж байлаа. “Автомашин үйлдвэрлэгчид үйлчлүүлэгчидтэй тогтоосон холбоогоо алдаж, ердөө шеринг үйлчилгээ эрхлэгчдийн ханган нийлүүлэгч болж хувирах тун таагүй байр сууринд шилжих нь”. Автомашин үйлдвэрлэгчид ч тулгарч буй эрсдэлийг мэдэрцгээж байна. Daimler болон BMW үйлчилгээнийхээ цар хүрээг тэлэх



зорилгоор car sharing компаниудаа нэгтгэлээ. Volkswagen компани Хамбург хотноо MOIA car shar-

ing-ийн үйлчилгээ туршиж эхлэв. General Motors компани Lyft Inc-д хөрөнгө орууллаа.

Alphabet-ын туршилтын салбар опиоид тахалтай тэмцэнэ

Кристен Браун

Alphabet-ын анагаах ухааны туршилтын салбар Verily компани АНУ-д тахал болж хувираад буй опиоид төрлийн мансууруулах бодисын донд ноцтой нэрвэгдсэн муж улсын нэг Охайогийн эмнэлгүүдтэй хамтран ажиллахаар төлөвлөж байна. Тус компани мансууруулах бодисын донтой хүмүүсийг технологид түлхүү суурилсан аргаар эмчлэх зорилго тавьжээ. Бие даасан, ашгийн бус OneFifteen хэмээх донгоос гаргах эмчилгээний байгууллагыг орон сууц, бихевиор эмчилгээний төвийн хамтаар Дэйтон хотноо байгуулах гэж байгаагаа Verily мягмар гарagt мэдэгдсэн юм. Мансууруулах бодист донтогсдод үзүүлэх эмнэлгийн тусламжийг сайжруулахын тулд Verily компанийн өгөгдлийн төвд түшиглэн эмнэл зүйн

аналитик шинжилгээ хийх юм. Туршилтын төслийн клиник арчилгаа сувилгаанд Premier Health-ийн салбар Samaritan Behavioral Health компани хамтарч Kettering Health Network түншээр оролцоно. Сэтгэцийн эрүүл мэндийг сахин хамгаалж, донгоос салгах Verily-н төлөвлөгөө нь эрүүлийг хамгаалах салбарт Alphabet-ын хэрэгжүүлж буй олон ажлын ганц жишээ төдий. Alphabet нь Verily болон бусад салбараараа дамжуулан шумуулаар тархдаг халдварыг устгах, эрүүлийг хамгаалах салбарт хиймэл оюун ухаан нэвтрүүлэх, хөгшрөх явцыг молекулын түвшинд судлах зэрэг олон ажил эрхэлдэг. Тус компани Google Health салбараа хөгжүүлэхийн тулд Geisinger Health-ын гүйцэтгэх захирал байсан Дэвид Фэйнбергийг хөлслөөд байгаа юм.



“Verily-н эмч, инженер, эрүүлийг хамгаалахын мэргэжилтний баг опиоид хямралын шалтгааныг нарийвчлан судалж үзсэний

эцэст манай нийгмийн бүх талыг хамарсан цогц бэрхшээл илрүүлээ” хэмээн Verily блог постдоо тайлбарлажээ. “Бэрх-

шээлийг шийдвэрлэхэд тулгарч буй гол хүндрэл бол донгоос сэргийлэх, донгоос салахад тодорхой хувь хүн, бүлэг хүмүүс,

хууль тогтоогчдод чиг гаргаж өгөхүйц чанартай мэдээлэл хомс байгааг явдал гэж дүгнэлээ.” Опиоид тахлын тархалтыг зогсоох нь тус компанийн хамгийн зоримог санаачилга байж болзошгүй. Опиоид төрлийн бэлдмэлийн тун хэтрүүлснээс үүдэн зөвхөн 2017 онд АНУ-д 50,000 хүн энджээ. АНУ-ын Эрүүл Мэндийн Үндэсний Хүрээлэнгийн статистикийг үзвэл, опиоидын тун хэтрүүлснээс үүдэлтэй үхлийн тоогоор тэргүүлж буй гол таван муж улсын нэг нь Охайо. Тус муж улсад опиоидын тун хэтрүүлсний улмаас эрсэдсэн хүний тоо нийт АНУ-ын дунджаас хоёр дахин их. Дэйтон дахь шинэ төв өвчтнүүдээ энэ хавраас хүлээн авч эхэлнэ. Иж бүрэн үйлчилгээтэй кампус 2020 он гэхэд ашиглалтад орох юм.

АЛБАН ЕСНЫ ДИСТРИБЬУТЕР

БОДИЗ АВТОМОТИВ

THE AUTOMOTIVE EXPERT

MAZDA CX-5

SKYACTIV TECHNOLOGY

Хурдны гайхамшиг
Хөдөлгүүрийн хувьсгал

88111939, 88021939

sales@bodizautomotive.mn

www.bodizautomotive.mn

www.facebook.com/bodizautomotive

Эдийн засаг

МӨНГӨНИЙ БОДЛОГО



Б.Хасуй / ЗГМ©

Эдийн засгийн өсөлтийг мөнгөний бодлого эрчимжүүлэв

Банкны салбарын эрсдэл даах чадвар сайжирч, эдийн засгийн өсөлтийг дэмжжээ

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM





цаашид тууштай нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага манай улсад тулгарч байгаа. Учир нь, улсын гадаад өрийн хэмжээ 27.9 тэрбум ам.доллар байгаа нь валютын нөөцөө нэмэгдүүлэхэд шахалт үзүүлсээр байна. Үүний дарамтыг сааруулж, эдийн засгийн тусгаар тогтнолоо хангахад мөнгөний бодлого 2016 оноос хойш чиглэж буй. Валютын нөөц 2018 онд 2017 онтой харьцуулахад 9.5 хувиар нэмэгдэж, алтны тушаалт 22 тонныг давсан билээ. Алтны тушаалт жилд 700-800 орчим сая ам.доллараар валютын нөөцийг нэмэгдүүлж байна.

● **Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр, хэрэглээний үнийн индекс төв банкны зорилтот нам түвшинд тогтвортой хэвээр байна.**

● **Төсөв тэлж, улсын гадаад, дотоод өрийн дарамт нэмэгдсэн ч мөнгөний бодлого эдийн засгийн бодит өсөлтийг дэмжжээ.**

● **Ам.долларын ханшийн өсөлтийг тухайн үед зах зээлийн бус аргаар тогтоох гэж оролдсон бол өнөөдөр бид валютын нөөцөө гөвчихсөн байх байлаа.**

Ам.долларын ханшийн өсөлтийг тухайн үед зах зээлийн бус аргаар тогтоох гэж оролдсон бол өнөөдөр бид валютын нөөцөө гөвчихсөн байх эрсдэл тун ойр байсан. Гэвч ийм замыг төв банк сонгосонгүй. Үүний ачаар валютын нөөц төгрөгийн ханшийн огцом уналтыг тогтворжуулж, үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэл бага багаар сэргэж байна. АНУ-ын Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ ойр ойрхон нэмэгдүүлж, хөгжиж буй болон хөгжингүй орнуудад



ам.долларын ханшийн чангарал бүхэлдээ дарамт, сорилт болж, хүндрэл үүсгэсээр. Энэ үед манай улс ч ялгаагүй валютын ханшийн дарамтыг бусдын адил мэдэрч яваа. Гол нь үе үеийн Засгийн газрын олон улсын зах зээлээс өндөр хүүтэй босгосон өр төлбөрийн эрсдэл эдийн засагт хүч түрэн мэдрэгдэх болсон. Ийм үед мөнгөний бодлогоор дамжуулан төгрөгийн ханшийг хамгаална гэдэг амаргүй. Төв банкны хувьд богино хугацаанд ханшийг тогтвортой байлгаж, огцом савлагаа гаргахгүй байх үүднээс зах зээлд бараг л тэрбум ам.доллар нийлүүлжээ. Эдгээр нь 2018 онд эдийн засаг зургаан хувиар өсөхөд нөлөөлснийг эдийн засагч Ч.Хашчулуун онцолсон юм.

Манай улсын санхүүгийн зах зээлийн цөм нь банкны салбар. Тус салбарын эдийн засагт гүйцэтгэх үүрэг, нөлөөлөл нь жилээс жилд тэлж, томорч байгаа. Монголбанкны ерөнхийлөгчөөр 2016 онд сонгогдсон Н.Баяртсайханы хувьд эрүүл, чийрэг банкны тогтолцоог бий болгох, энэ салбарын тогтвортой, найдвартай байдлыг бэхжүүлэхэд томоохон алхам хийсэн нь хууль эрх зүйн орчны шинэчлэл. Банкны салбарын дархлааг нэмэгдүүлж, төв банкны хараат бус бие даасан байдал сүүлийн гурван жилийн хугацаанд эрс сайжирсан гэж хэлж болох юм. Тодруулбал, банкны салбарын эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд 10 гаруй хуулийн төсөл боловсруулж, дэлхийн жишгээр буюу “нэг хэл”-ээр ярих нөхцөл бүрдээд байна. Банкны активын чанар сайжирч, 2018 оны турш нийт хагас их наяд төгрөгөөр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж, 3.4 их наяд төгрөгт хүргээд байна. Өөрийн хөрөнгийн үзүүлэлт сайжрах тусам банкны эрсдэл даах чадвар нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд үлэмж нөлөө үзүүлэх нь дамжиггүй. Банк давамгайлсан тогтолцоотой санхүүгийн зах зээлд мөнгөний бодлого тогтвортой, тууштай хэрэгжсэнээр дээрх үр дүн эдийн засагт гарчээ. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

10

Хувь. Монголын хөрөнгийн биржийн нийт арилжааны үнийн дүнгийн таваас дээш хувьтай тэнцэх хэмжээний гүйлгээг 2018 онд хийсэн нэр бүхий зургаан гишүүн үнэт цаасны компанийг энэ оны гишүүнчлэлийн жилийн хураамжаас тус бүр 10 хувийн хөнгөлөлт эдлүүлэхээр боллоо. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2.4 их наяд төгрөгтэй тэнцэж байна.

» БАНК, САНХҮҮ

66

Хувь. Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 2018 оны жилийн эцэст 1.3 их наяд төгрөгт хүрч, 2016 онтой харьцуулахад 66 хувиар өсчээ.

» УУЛ УУРХАЙ

1677

Лиценз. Улсын хэмжээнд нийт 3085 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр бүртгэлтэй байгаагаас 54.4 хувь буюу 1677 нь ашиглалтын лиценз байна.

» ТӨСӨЛ

24.6

Тэрбум төгрөг. Улсын төсвийн хөрөнгөөр энэ онд геологийн 26 төслийг нийт 20.5 тэрбум төгрөгөөр, шинээр хэрэгжүүлэх 17 төслийг 4.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд нийт 24.6 тэрбум төгрөгийг геологийн судалгааны ажилд зарцуулахаар шийдвэрлэжээ.

» ХӨРШ

30

Үйлдвэр. БНХАУ агаарын бохирдлыг бууруулах хүрээнд Хөбэй мужийн гангийн үйлдвэрийг цөөлөх бодлого хэрэгжүүлж эхэллээ. 2020 он гэхэд гангийн үйлдвэрийн тоог 30, 2025 он гэхэд 25 болгож бууруулна гэж мэдэгдэв.

» ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Хөгжлийн банкны дэргэдэх “Ди Би Эм Лизинг” компани аж ахуйн нэгжийн тоног төхөөрөмжийн шинэчлэлтээр ОХУ-ын компаниудаас 740 гаруй техник, тоног төхөөрөмж оруулж ирэн 230 гаруй аж ахуйн нэгжүүдэд олгоод байна.

» ҮЙЛЧИЛГЭЭ

3.7

Сая төгрөг. Улсын хэмжээнд есөн хүн тутмын нэг нь ББСБ-аас зээлийн үйлчилгээ авч байна. Нэг зээлдэгч дунджаар 3.7 сая төгрөгийн зээлтэй байна.

» ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

99

Хувь. Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлагын 98-99 хувийг ажилгүйдлийн тэтгэмжийн зардал эзэлж байна.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,631.45
Евро	2,979.06
Японы иен	23.93
ОХУ-ын рубль	40.06
БНХАУ-ын юань	388.28
БНСУ-ын вон	2.34

УУЛ УУРХАЙ

БНХАУ-ын нүүрсний импортоо хязгаарлах бодлого Монголд боломж олгоно гэв

Т.Элиса
Шинжээч

“БНХАУ-ын нүүрсний импортоо хязгаарлах бодлого Монголын нүүрс экспортлогчдод боломж болно” гэж үзэж байгаагаа Aspire Mining компанийн тэргүүн Дэвид Полл онцолж байна. IHS Markit-ийн тооцоолсноор

2018 онд БНХАУ-ын нүүрсний импортын 44 хувийг Австрали, 43 хувийг Монгол Улс нийлүүлжээ. Гэхдээ ойрын жилүүдэд энэ байр солигдож, Монгол Улс нүүрсний нийлүүлэлтээрээ тэргүүлнэ гэж таамаглаж байна. Aspire Mining-ийн хувьд жорк стандартаар тогтоосон 281.1 сая тонн нүүрсний нөөц бүхий Овоот коксжих нүүрсний төслийн

эхний шатны урьдчилсан ТЭЗҮ-ийг энэ сард боловсруулж дуусах юм. Монгол болон Торонтогийн Хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй Erdene Resource Development компани Хөндий алтны төслийн бие даасан урьдчилсан эдийн засгийн тооцооллоо Канадын цахим тайлан мэдээний “sedar” системд нийтэлсэн байна. Нэг унц алтыг 1200 ам.доллараар

тооцвол төслийн өгөөж 56 хувь байхаар тооцож байгаа аж.

Анхны хөрөнгө оруулалт 32 сая ам.доллар гэж үзэж байна. “Хөндий” төсөлд багтаж байгаа “Баян хөндий” ордын олборлолтын лиценз авах хүсэлтээ гаргажээ. Нэгдүгээр улиралд багтаан шийдвэр гарна гэж тооцож байгаа бол хоёр дахь орд болох “Алтан нар” төсөлд

олборлолтын лицензээ авах хүсэлтээ хоёрдугаар улиралд багтаан гаргахаар төлөвлөсөн байна.

Үүнээс гадна Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Kincoга Corper компани нэг бүрийг нь 0.12 канад доллараар үнэлж, 787 мянга 500 ширхэг хувьцаа хаалттай хүрээнд гаргахаар бэлтгэж байна.

Эдийн засаг

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Ноолуурын чанар “ногоон”-ы хэмжээг тодорхойлно

Түүхий эдийн чанараа сайжруулахгүйгээр зах зээлээ тэлэх талаар яриад ч хэрэггүй

▲1 Геометрийн прогрессоор өссөн малын тоо толгой нь бэлчээрийн даацаас хэд дахин давж, байгаль экологид сөрөг нөлөө үзүүлж эхэлснийг дотоод, гадаадын судлаачид анхааруулсаар байгаа. Бэлчээрийн хомсдол нь малын эрүүл мэнд, чанарт нөлөөлж, эргээд мал аж ахуйн салбарын үр шим, өгөөжөөс тэмтэрч эхэлсэн байна. Манай мал аж ахуйн салбарт чанар хэмээх ойлголт мартагдсан. Тухайлбал, ноолуурыг чанараар нь бус жингээр нь тооцож худалдан авдаг. Тиймээс малчид ноолуурын гарц сайтай нас гүйцсэн ямаа өсгөхийг илүүд үзэх болжээ. Гэтэл ямааны нас гүйцэх тусам ноолуурын ширхэг бүдүүсдэг. Мөн гурав ба түүнээс дээш настай эр ямааны тоо толгой эрс нэмэгдсэн нь монгол ноолуурын чанарт нөлөөлж эхэлжээ.

- Ноолуурыг чанараар нь бус жингээр нь тооцож худалдан авдаг учраас малчид гарц сайтай нас гүйцсэн ямаа өсгөхийг илүүд үзэх болжээ
- Судалгааны Bain and Company байгууллагын тайланд дурдсанаар дэлхийн ноолуурын зах зээлд жилд дунджаар 4.3 тэрбум ам.доллар эргэлддэг байна.
- Дэлхийн нэхмэл, сүлжмэлийн салбар дахь амьтны гаралтай нийт ширхэгтийн ердөө нэг хувийг эзэлж буй энэ үед малын гаралтай органик таваарын эрэлт хийгээд үнэ цэнэ жилээс жилд өсөхөөр байна.

Ноолуурын ширхэг нарийн байх тусам эцсийн бүтээгдэхүүн нь хөнгөн бөгөөд зөөлөн байдаг аж. Уг нь монгол ямааны ноолуурын ширхэгийн голч 13-16 микрон, урт нь 38-43 миллиметр. Эдгээр үзүүлэлтийг Хятад, Энэтхэг, Иран зэрэг оронтой харьцуулахад голч нь



нарийнд тооцогддог. Гэхдээ сүүлийн жилүүдэд дэлхийд дээгүүрт биачигддэг чанарын эрэмбээ бид алдах эрсдэлтэй нүүр тулсан байна. Учир нь өмнөд хөрш чанар сайтай ноолуур өгдөг ямааны үүлдэр угсааг олшруулж, түүхий эдийн чансаагаар дэлхийн зах

зээлд цахиур хагалаад байна. БНХАУ-ын Засгийн газар 2013 оноос энэ чиглэлд анхаарч, багагүй хөрөнгө оруулалт хийжээ. Энэ хүрээнд нарийн ширхэгт ноолуурын гарцтай ямааны үүлдэр угсааг үржүүлж, цагаан ямааг дагнан өсгөснөөр энэ зах зээлийн идэвхтэй тоглогч









болоод зогсохгүй хөрөнгө оруулагчдын харааг булааж чаджээ. Уг нь манайд ямааны шилмэл үүлдэр угсаа бий. Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын “Баяндэлгэр” омог, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын “Залаа жинстийн цагаан”

зэргийг шилмэл үүлдрийг нэрлэж болно. Шилмэл үүлдрийн омгийг олшруулах нь чухал. Ялангуяа, гарц их, голч нарийн ноолургтай ямааны омгийг бий болгох шаардлагатайг хөдөө аж ахуйн салбарын эрдэмтэн Б.Баасансүх хэлж байна. Мөн ноолуур нийлүүлэх болон

боловсруулах сүлжээгээ ч сайжруулах хэрэгтэй. Ноолуур худалдан авахад чанарыг жанжин шугам болгох нь чухал байгааг судлаачид анхааруулж байгаа юм. ХХААХҮЯ олон улсын байгууллагуудтай хамтран монгол ноолуурын өнгө, давуу шинж чанарт тулгуурлан “Монголын хаан ширхэгт” брэндийг хөгжүүлж, зах зээлд таниулан сурталчлахаар зорьж байгаа. Энэ хүрээнд шилмэл үүлдрийн ямааны үүлдэр угсааг сайжруулах, монгол ноолууран бүтээгдэхүүнийг “Монголын хаан ширхэгт” чанарын гэрчилгээгээр олон улсын зах зээлд гарахаар төлөвлөж буй аж. Мэдээж олон улсын зах зээлд монгол ноолуур болохыг гэрчилсэн нотолгоо, тэмдэгтээр баталгаажуулж болно. Гэхдээ энэ бүхний цаана монгол малын эрүүл мэнд, генетикийн нөөцийг сахин хамгаалах их ажил үлдэж буй. Монгол малын эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, малын тоо, сүргийн бүтцийг зохистой хадгалах гээд энэ салбарын малгай дор хөндөгддөг олон асуудлыг цогцоор нь шийдэхгүйгээр ноолуураа ногоон валют болгох бидний мөрөөдөл дорвитой урагшлахгүй л байх юм. Ноолуур бол Монгол Улсын стратегийн түүхий эд. Монгол Улсын нийгэм, эдийн засагт чухал үүрэгтэй ямаан сүргийн эрүүл мэнд, ноолуурын түүхий эдийн чанар энэ салбар төдийгүй манай эдийн засгийн ирээдүйг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэнэ. Бид түүхий эдийн чанар, чансаагаа сайжруулахгүйгээр зах зээлээ тэлэх, дэлхийн хэмжээний тоглогчийн байр сууриа хадгалах талаар яриад ч хэрэггүй. Ялангуяа, амьтны гаралтай ширхэгт нь дэлхийн нэхмэл, сүлжмэлийн салбар дахь нийт ширхэгтийн ердөө нэг хувийг эзэлж буй энэ үед малын гаралтай органик таваарын эрэлт хийгээд үнэ цэнэ жилээс жилд өсөхөөр байна. Энэ өрсөлдөөнд бид чанараар л ялгарч байж дэлхийн зах зээл дэх байр сууриа хадгалж, цаашлаад ахиулж чадна. Судалгааны Bain and Company байгууллагын тайланд дурдсанаар дэлхийн ноолуурын зах зээлд жилд дунджаар 4.3 тэрбум ам.доллар эргэлддэг байна. Манай улсын ДНБ-ий талтай тэнцэх энэ мөнгөнөөс бид хэдийг хүртэж, Монгол Улс дэлхийн ноолуурын зах зээлд хэр хүчтэй тоглогч байх нь малын тоо толгойноос гадна түүхий эдийн чанараас хамаарна гэдгийг санах нь зүйтэй болов уу. [ЗГМ]



ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:



DOW JONES	S&P 500	FTSE 100	NIKKEI 225	TOPIX	SHANGHAI COMPOSITE	HANG SENG	KOSPI
0.2%	0.09%	1.06%	1.8%	1.8%	1.3%	0.7%	0.17%